

## БҮГД НАЙРАМДАХЧУУДЫН ОЛОН УЛСЫН ХҮРЭЭЛЭН



Ардчилалыг Дэлхий Дахинд Бэхжүүлнэ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬ

2008 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

СОНГУУЛИЙН АЖИГЛАЛТЫН ЭЦСИЙН ТАЙЛАН

# Монгол Улсын Их Хурлын Сонгууль 2008 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

## Сонгуулийн Ажиглалтын Эцсийн Тайлан



### Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн

1225 Eye Street, NW, Suite 700  
Washington, DC 20005  
[www.iri.org](http://www.iri.org)

*Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (ОУХА)-аар дамжуулан Америкийн ард түмэн болон Монгол дахь Япон Улсын Элчин Сайдын Яамны гүн дэмжлэгтэйгээр энэхүү тайланг бэлтгэв. Тайланд тусгасан үзэл бодол нь эл тайланг бичигчийнх бөгөөд ОУХА, АНУ-ын Засгийн газар, Япон Улсын Засгийн газрын байр суурийг шууд илтгэхгүй.*

© 2008 IRI. All Rights Reserved  
Зургийг: Чанатип Бункает



## ГАРЧИГ

<b>Ерөнхий хураангуй</b>	5
<b>I. Оршил</b>	7
<b>II. Сонгуулийн өмнөх орчин</b>	9
А. Улс төрийн орчин	
Б. Хууль эрх зүй, удирдлагын орчин УИХ-ын Сонгуулийн тухай хууль Сонгуулийн удирдлага	
<b>III. Сонгуулийн өдөр ба санал тоолох үйл явц</b>	25
А. Санал авах байр, орчин ба бэлтгэл	
Б. Санал авах үйл явц	
В. Урьдчилсан санал ба зөөврийн саналын хайрцаг	
Г. Улс төрийн намын ажиглагчид	
Д. Саналын хуудас тоолох ба сонгуулийн дүнг мэдээлэх	
<b>IV. Зөвлөмжүүд</b>	41
<b>V. Хавсралтууд</b>	47
А. Төлөөлөгчдийн нэрс	
Б. АНДАТГ-ийн төлөөлөгчдийн 2008 оны 6 дугаар сарын 30- ний өдөр гаргасан урьдчилсан мэдэгдэл	
В. Товч танилцуулга: Ази Номхон Далайн Ардчиллын Төлөө Түншлэл	
Г. Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хорооноос гаргасан УИХ-ын 2008 оны сонгуулийн нэгдсэн дүн: 2008 оны 7 дугаар сарын 14- ний өдрийн байдлаар	
Д. Гадаадын ажиглагч Монгол Улсын Их Хурлын сонгуулийг ажиглах тухай журам	
Е. Санал тоолох, дүн гаргах ажлыг зохион байгуулах заавар	



## Ерөнхий хураангуй

Монгол Улсын Засгийн газар болон Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ)-ны урилгаар 16 гишүүний бүрэлдэхүүнтэй олон улсын төлөөлөгчид 2008 оны 6 дугаар сарын 29-ний өдөр болсон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үйл явцыг ажиглав. Ази Номхон далайн Ардчиллын Төлөө Түншлэл (АНДАТТ) байгууллагын дэмжлэгтэйгээр Австрали, Канад, Индонези, Япон, Филиппин, БНСУ, Тайланд, Зүүн Тимор, АНУ зэрэг орнуудын сонгуулийн байгууллага, засгийн газрын ажилтнууд, иргэний нийгмийн төлөөлөгчид болон парламентийн гишүүнээс бүрдсэн ажиглагчдын баг сонгуулийн үйл явцыг ажиглав. (Хавсралт А, Б).

АНУ-ын нийслэл Вашингтон хотноо орших Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн (БНОУХ) АНДАТТ-ийн ажиглагчдын багийн зохион байгуулалтын ажлыг хариуцаж гүйцэтгэлээ. Энэхүү тайланг АНДАТТ-ийн төлөөлөгчдийн ажиглалтад тулгуурлан БНОУХ бэлтгэсэн тул үүнд тусгагдсан зүйлс АНДАТТ-ийн төлөөлөгчид болон тэдний төлөөлж буй засгийн газар, байгууллагын байр суурийг илэрхийлэхгүй болно.

АНДАТТ-ийн ажиглагчдын баг сонгуулийн өмнөх өдрүүдэд Монголын улс төрийн намуудын төлөөлөгчид, сонгуулийн хорооны ажилтнууд, иргэний нийгмийн төлөөлөгчидтэй хэд хэдэн удаа уулзалт, ярилцлага хийсэн. Сонгуулийн өдөр (2008 оны 6 дугаар сарын 29-ний өдөр) ажиллагчдын есөн баг Улаанбаатар хотын *тав*, төвийн бүсэд орших Дархан-Уул, Хэнтий, Орхон, Сэлэнгэ аймгуудад *дөрөв*, нийт есөн тойрогт очиж санал өгөх явцыг ажиглав.

Сонгуулийн өдөр нийт 1,704 сонгуулийн хэсгийн хороо (СХХ) орон даяар ажилласнаас АНДАТТ-ын ажиглагчид болон БНОУХ-ийн эрх бүхий ажилтнууд 100 гаруй хэсгийн хороодын

санал авах байранд очиж санал авах бүхий л үйл явцыг ажиглав. Төлөөлөгчид нийт хэсгийн хороодын 1500 гаруй ажилтнууд, мянга мянган сонгогч иргэдтэй уулзаж ярилцсан байна. Сонгуулийн өдрийн өглөө АНДАТТ-ийн ажиглагчид хуваарилагдсан сонгуулийн тойрогтоо очиж хэсгийн хороод санал авах байрыг нээж санал авч эхлэх үе шатыг ажигласнаас гадна сонгуулийн өдрийн турш санал авах явц болон саналын хуудас тоолох үеийн эхний шатуудыг ажигласан болно.

## I. Оршил

Тус тайланд тусгасан ажиглалтын үр дүн, санал, зөвлөмж нь ажиглагчдын ажиглалт хийсэн сонгуулийн өмнөх гурван өдөр, Сонгуулийн өдөр, мөн санал тоолох, сонгуулийн дүнг зарлах эхний үе шатыг биечлэн ажиглаж, сонссон зүйлсэд тулгуурласан болно. Энэхүү тайланг бэлтгэх ажил нь 7 дугаар сарын 1-ний өдөр гарсан эмх замбараагүй явдал, улсын хэмжээн дэх 26 тойргоос 3 тойргийн сонгуулийн дүнтэй холбоотой маргаан, өмнөх Засгийн газрын үйл ажиллагаа 7 дугаар сарын 29-нөөр дуусгавар болоход дараагийн шинэ Засгийн газар бүрдэхгүй сунжирсан зэрэг сонгуулийн дараахь болон түүнээс улбаалсан үйл явдлуудтай зэрэгцэн явагдсан болно. Гэвч сонгуулийн дараахь үйл явдал болон нотлох баримтгүй цуу ярианаас шалтгаалж тайланд тусгах ажиглалтын үр дүнг хойшлуулах нь зүйд нийцэхгүй гэж төлөөлөгчид үзэв.

УИХ-ын сонгуулийн үйл явц үндсэндээ эерэг явагдсан бөгөөд сонгуулийн дүн Монголын ард түмний нийтлэг хүсэл зоригийг илтгэсэн болно. Харьцангуй богино хугацаанд эрчимтэй, тайван замаар явагдсан сонгуулийн сурталчилгаа нь Монгол Улсын сонгогч-иргэдэд ойлгомжтой, олон ургальч улс төрийн сонголт хийх боломж нөхцлийг бодитой бүрдүүлж байсан. Сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулалтын өндөр түвшинд хэрэгжүүлсэн төдийгүй Сонгуулийн өдөр сонгогчид өөртэй итгэлтэй, дэг журамтай сонгуульд оролцож байгаа нь харагдсан. Сонгуулийн явц ил тод явагдсанаас гадна сонгуулийн үр дүнг өргөн хүрээнд, системтэйгээр гажуудуулахын эсрэг хяналт шалгалтын шаардлагатай арга хэрэгсэл хангалттай бүрдсэн нь ажиглагдсан. Сонгуулийн удирдлагын тогтолцооны бүх түвшинд, түүнчлэн сонгуулийн хэсгийн хороодод улс төрийн нам, эвслийн төлөөлөл зохистой байгаа нь харагдсан. Түүнчлэн АНДАТТ-ийн төлөөлөгчдийн очиж ажигласан сонгуулийн хэсгийн хороодын санал авах,

санал тоолох байранд ажиллаж байсан улс төрийн нам, эвслийн ажиглагчидтай уулзаж ярилцах үеэр нам бус (дотоодын) ажиглагчид байхгүй байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Сонгогчдын нэрсийн жагсаалтад хэт олон сонгогч бүртгэгдсэн, мөн санал тоолох болон сонгуулийн дүнг нэгтгэх явц удааширсан зэрэг нь сонгуулийн үйл явцыг сулруулах хүчин зүйл болж, улмаар сонгуулийн дараах зөрчил маргааны тухай таамаг яриа гарахад зарим талаар нөлөөлсөн гэж ажиглагчид дүгнэсэн. Гэвч асуудлын гол нь эдгээр сул талуудыг бодитой түвшинд үнэхээр ашиглах боломж байсан буюу ашигласан эсэхэд оршино.

АНДАТТ-ийн төлөөлөгчдийн ажиглалтад тулгуурлах аваас эдгээр сул талыг ашиглаагүй байх бүрэн магадлалтай ч, санал тоолох болон сонгуулийн дүнг зарлах үеэр хэсгийн хороод дээр цөөн тооны ажиглагчид ажилласныг дурдах нь зүйтэй.

Сөрөг хүчин болох Ардчилсан нам (АН) болон бусад нам, эвслийн удирдлагын зүгээс сонгууль зөрчилтэй явагдсан гэж үзсэн нь АНДАТТ-ийн ажиглагчдын хэсгийн хороодод очиж, санал өгөх ба санал тоолох үйл явцыг ажиглаж харсан зүйлстэй нийцэхгүй байна. Гэвч АНДАТТ-ийн төлөөлөгчдийн ажиглалт, дүгнэлтийг өргөн цар хүрээтэй дүр зургийн нэгээхэн хэсэг гэж үзэх нь зүйтэй төдийгүй зөрчлийн талаарх таамаг яриа ноцтой байж болох түвшнийг үгүйсгэх буюу багасгах нөхцөл болохгүй. Эдгээр таамаглалыг нарийвчлан анхаарч, бодит үнэнийг нягтлан тогтоох шаардлагатай.

Эцэст нь дүгнэхэд, Монголын ард түмэн шинээр сонгогдсон засгийн газрын улс төрийн чиг шугамаас үл хамааран шударга ёсоор сонгогдсон гэдэгт итгэл төгс байх нь хамгаас чухал билээ. Ийм итгэл үнэмшил байхгүй бол сонгуулиар жинхэнэ ялагчид тодрохгүй.

## **II. Сонгуулийн өмнөх орчин**

Сонгуулийн өмнөх өдрүүдэд Монголын нийгэм, улс төрийн төлөөлөгчидтэй АНДАТТ-ийн ажиглагчид нэлээд олон уулзалт, ярилцлага хийснээс ажиглагдсан дүр зургаар бол сонгуулийн үйл явц шударга, дэг журамтай явагдаж байв.

### **A. Улс төрийн орчин**

Улаанбаатар хотод 7 дугаар сарын 1-ний өдөр гарсан нийтийн эмх замбараагүй байдлаас үүдэн таван хүний амь нас эрсдэж, их хэмжээний эд хөрөнгийн хохирол учирсан явдал нь засаг захиргааны ерөнхий бэлтгэл, сонгуулийн өмнөх сурталчилгааны харьцангуй тайван нөхцөл байдлын эцэст санаанд оромгүй төгсгөл болсон билээ. Сонгуулийн өмнө олон нийт төдийгүй улс төрийн нам, эвслээс нэр дэвшигчдийн сэтгэл санаа нэлээд эерэг харагдаж байсан.

Улс төрийн хоёр гол нам – Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН) болон Ардчилсан намын аль аль нь сонгуулийн дүн эерэг гарна гэдэгт итгэл төгс байгаагаар илэрхийлж байсан хэдий ч санал авах ажлыг зөв зохион байгуулах, саналын хуудсыг үнэн зөв тоолж, сонгуулийн дүнг зарлах үүрэгтэй сонгуулийг зохион байгуулагчдын чин хүсэл эрмэлзэлд бага зэрэг сэтгэл зовниж байгаа нь харагдаж байсан. Олон нийтийн санал асуулга, нэр дэвшигчдийн өрсөлдөөнт мэдэгдэл, сурталчилгаанаас харвал сонгуулийн дүн маш ойролцоо гарна гэсэн олон нийтийн хүлээлт ажиглагдаж, сонгогчдын ирц нэлээд өндөр байх төлөвтэй байв.

2008 оны 5 дугаар сарын 8-ний өдөр сонгуулийн сурталчилгааг албан ёсоор зарласнаас хойшхи хугацаанд сонгуультай холбоотой аливаа ноцтой эмх замбараагүй байдал гарсан гэх баримт нотолгоо ажиглагчдад олдоогүй буюу мэдэгдээгүй. Сонгуулийн сурталчилгаа бүхий л талаар нээлттэй, тайван замаар явагдаж байгаа харагдсан.

Олон нийтийн болон хувийн өмчит хэвлэл мэдээллийн хэрэгслийг нээлттэй, тэнцвэртэй ашиглах боломжтой нь ажиглагдсан. Олон нийтийн газруудад улс төрийн яриа таниулга өргөн хэмжээнд, саадгүй болж байгаа харагдсан. Улаанбаатар хотын дүүргүүдэд маш олон залуус сурталчилгааны материал түгээж байгааг олонтаа харж болохоор байв. Сонгуулийн сурталчилгаа бүхий зурагт хуудас, самбарыг олон газруудад байрлуулсан байсан. Сонгуулийн хуулийг зөрчсөн гэх хардалтаас үүдэн, өрсөлдөж буй улс төрийн намууд, нэр дэвшигчдийн хооронд нэгнийхээ эсрэг гаргасан гомдол шаардлага нь улс төрийн кампанит ажлын ердийн жишгийн хүрээнд болж буй санагдсан.

Сонгуульд оролцохыг хүссэн аль нэг нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн эсрэг улс төрийн шалтгаанаар хууль эрх зүйн болон захиргааны хориг саад учруулсан гэх мэдээлэлийг уулзалт ярилцлагын үед төлөөлөгчид аваагүй болно. Түүнчлэн нэр дэвшигчдийг бүртгэхтэй холбоотой бэрхшээл гарсан талаар улс төрийн гол намуудыг зүгээс манай ажиглагчдад мэдээлээгүй болно. УИХ-ын 76 суудлын төлөө өрсөлдөхөөр нийт 356 нэр дэвшигчид зохих ёсоор бүртгүүлсэн ажээ. Орон нутгийн зарим ажилтан, төрийн байгууллагаас МАХН-ыг дэмжигчдэд хуурамч үнэмлэх, гэрчилгээ тараасан гэх шүүмжлэл хожим гарч байсан ч нам, эвслүүд төрийн эх үүсвэрийг сонгуулийн сурталчилгаанд өргөнөөр ашигласан талаар ажиглагчдад мэдээлсэн буюу харж ажигласан зүйл байгаагүй.

Сонгуулийн өмнөх өдрүүдэд манай ажиглагчид сонгуулийн тойргийн болон хэсгийн хороод улс төрийн бүх хүчний төлөөллөөс бүрдсэн болохыг ажиглаж нягталсан. Бараг сонгуулийн бүх хороодын удирдлага буюу дарга, нарийн бичгийн даргын албан үүргийг АН болон МАХН-ын гишүүд гүйцэтгэж байсан бөгөөд үүнээс үүдсэн ямар нэг бухимдал, эгдүүцэл ажиглагдаагүй. Бодит байдалд сонгуулийн хороодын

дотоод уур амьсгал эерэг, гишүүд нь харилцан хүндэтгэлтэй харилцаж байсныг ажиглагчид сонгуулийн өдрийн туршид харж байсан.

## **Б. Хууль эрх зүй, удирдлагын орчин**

### **УИХ-ын Сонгуулийн тухай хууль**

Энэ сонгууль нь 2005 онд шинэчлэн баталсан УИХ-ын Сонгуулийн тухай хуулиар явуулж буй анхны сонгууль юм. Улс төрийн сурталчилгаа, сонгуулийн үйл ажиллагаа явуулах орчинг бүрдүүлсэн талаас авч үзвэл тус хууль нь үндсэндээ эерэг, амьдралд хэрэгжихүйц болжээ.

Гэвч сонгогчдын нэрсийн жагсаалт гаргах, сонгуулийн өдөр санал авах хугацаа, хэсгийн хороодод хуваарилсан нийт сонгогчдын тоо зэргийг зохицуулсан холбогдох заалтыг дараагийн сонгуулиас өмнө нарийвчлан хянаж үзвэл зохино.

Үүний зэрэгцээ тус хуульд эерэг заалтууд олон тусгагдсан байна. Тухайлбал ил тод байдлыг хангах, нам бус сонгуулийн байгууллага, санхүүгийн хяналт шалгалт, хариуцлагын тогтолцоо, хэвлэл мэдээллийн хэрэгслийн цагийг тэнцвэртэй хуваарилах зарчим, сонгогчдын оролцоог өндөр түвшинд хангах зэрэг заалтуудыг дурдаж болно. Дээрх заалтуудаас, ялангуяа сурталчилгааны санхүүжилт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн талаарх заалтыг хэрэгжүүлэх, хяналт тавихад зохих нөөц боломж, хүчин чармайлт гаргасан эсэх талаар төлөөлөгчдөд бүрэн тодорхой нягталж мэдэх боломж байгаагүй.

### **Олон мандаттай томсгосон тойрог бүхий сонгуулийн систем**

УИХ-ын Сонгуулийн тухай шинэ хуулиар бүрдүүлсэн хамгийн чухал практик ач холбогдолтой зүйл нь олон мандаттай томсгосон тойрог бүхий сонгуулийн тогтолцоонд оршиж байв. Энэхүү шинэ тогтолцоогоор нэг тойргоос

сонгогдох нэр дэвшигчдийн тоо тухайн тойргийн хүн амаас хамааран хоёроос дөрвөн хүн байх бөгөөд сонгуулийн 26 тойрог бүр харилцан адилгүй саналын хуудас хүлээн авчээ. Саналын хуудсанд жагсаах нам, нэр дэвшигчдийн тоо нь тухайн тойргийн мандатын тоо, мөн тус тойрогт өрсөлдөхөөр бүртгүүлсэн нам, нэр дэвшигчдийн тооноос хамаарч байв. Нэг нэр дэвшигчийн нэр зөвхөн нэг тойрогт тараагдах саналын хуудсанд нэг удаа бичигдэнэ.

Сонгуульд ялахын тулд тухайн нэр дэвшигч өрсөлдөж буй тойргийн мандатын тооноос хамааран хамгийн олон санал авсан эхний 2–4 нэр дэвшигчдийн тоонд багтах ёстой. Түүнчлэн нэр дэвшигч нь тухайн тойргийн нийт сонгогчдын 25%-иас доошгүй санал авснаар ялах боломж бүрдэнэ. Тухайн тойргийн сонгогчид хэдэн нэр дэвшигчдийн төлөө санал өгөх тоог тусгасан зааварчилгааг саналын хуудсанд ойлгомжтой тодорхой дурдсан байв. Харин хамгийн олон санал авч ялсан эхний 2–4 нэр дэвшигчдийн тоонд багтсан ч сонгогчдын 25%-иас дээш санал аваагүй нөхцөлд дахин сонгууль явуулж өрсөлдөнө. 2008 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар зарлагдсан сонгуулийн дүнгээс үзвэл ялалт байгуулж буй 76 нэр дэвшигчээс 25%-ийн босгыг хангаагүй нэр дэвшигч байхгүй байв. (Хавсралт Г).

#### Улс төрийн нам, нэр дэвшигчдийн бүртгэл

Сонгуульд өрсөлдөх улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчид, бие даан нэр дэвшигчдийг бүртгүүлэх талаар Сонгуулийн тухай хуульд дэлгэрэнгүй заалтууд тусгагдсан. Эдгээр заалтууд нь сонгуульд олон нам, эвсэл оролцоход хориг саад учруулахааргүй нь харагдсан. Сонгуульд улс төрийн нийт 11 нам, мөн гурван намыг нэгтгэсэн нэг эвсэл оролцсон. Бие даан нэр дэвшигчээр бүртгүүлж, сонгуульд өрсөлдөхийн тулд тухайн тойргийн харилцан адилгүй байршлаас 801 сонгогчийн үнэн бодит гарын үсэг цуглуулахаас гадна нас (25 нас хүрсэн байх), санхүүгийн чадавхи, гэмт хэрэгт холбогдоогүй байх зэрэг шаардлагыг хангасан байх

шаардлагатай. Сонгуульд өрсөлдсөн нийт 356 нэр дэвшигчээс 45 нь бие даан нэр дэвшигчид байсан бөгөөд тэднээс зөвхөн нэг нэр дэвшигч шинэ парламентад сонгогджээ.

УИХ-ын Сонгуулийн тухай хуульд улс төрийн нам, эвслээс нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байх тухай хуулийн зохицуулалт байсан хэдий ч УИХ-ын сонгуулийн өмнө энэ заалт хасагдсан. Шинээр бүрэлдсэн УИХ-д ердөө гурван эмэгтэй нэр дэвшигч сонгогдсон болон энэ сонгуульд улс төрийн нам, эвслээс цөөн тооны эмэгтэйчүүд нэр дэвшсэн нь дээрх заалтыг хүчингүй болгосноос үүдэлтэй гэж шууд дүгнэж болохгүй юм.

#### Ил тод байдал ба улс төрийн төвийг сахих зарчим

УИХ-ын Сонгуулийн тухай хуульд сонгуулийн процедурын ил тод байдлыг хангасан болон сонгуулийн байгууллагын улс төрийн хараат бус байдлыг баталгаажуулсан заалтууд тусгагдсан байна. Тухайлбал, сонгууль зохион байгуулах тогтолцооны бүх түвшинд өрсөлдөгч нам, эвслүүдийн төлөөллийг оролцуулах тухай заалтыг энд дурдаж болно.

Сонгуулийн санал авах, тоолох, саналын дүнг мэдээлэх бүхий л үйл явцыг гадаад, дотоодын ажиглагчдад ажиглах боломж бүрдүүлсэн заалтууд нь сонгуулийн процедурын ил тод байдлыг хангах, сонгуулийг төвийг сахисан хараат бус байдлаар явуулахад тодорхой хувь нэмэр оруулсан байна. Сонгуулийн зөрчил гэж үзсэн зүйлсээ дуу болон дүрс бичлэгт буулгах боломжийг улс төрийн намын болон гадаадын ажиглагчдад олгосон. Түүнчлэн хуулиар хэвлэл мэдээллийн байгууллагын эрх бүхий төлөөлөгчдийг санал өгөх бүхий л үйл явцад бичлэг хийх эрхээр хангасан. АНДАТТ-ийн ажиглагчид хэсгийн хороод дээр уулзаж ярилцсан нам, эвслийг төлөөлж буй ажиглагчдын бүрэлдэхүүн, тоо хэмжээнд сэтгэл хангалуун байсан төдийгүй зарим тойргийн хэсэгт хэвлэл мэдээллийнхэнтэй олон удаа тааралдаж байв.

АНДАТТ-ийн зарим төлөөлөгчдийн онцлон дурдсан нэг сул тал гэвэл сонгууль ажиглах бүрэлдэхүүнд иргэний нийгмийн төлөөлөл оруулах заалт хуулинд тусгагдаагүй явдал юм. Нам бус дотоодын ажиглагчдыг оролцуулах нь сонгуулийн шударга үйл явцад итгэх олон нийтийн итгэл үнэмшлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой гэдэгт ихэнх ажиглагчид санал нэгдэж байв. Сонгуулийн дараа болсон үйл явдал, нотлох баримтгүй таамаг яриа зэрэг нь нам бус иргэний нийгмийн ажиглагчдыг оролцуулахыг дэмжсэн АНДАТТ-ийн төлөөлөгчдийн байр суурь зөв болохыг харуулсан билээ.

### Сонгогчдын оролцоо

Сонгуульд оролцох иргэдийн оролцоог өндөр түвшинд хангахуйц нөхцлийг бүрдүүлж өгсөн УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн ач холбогдлыг АНДАТТ-ийн төлөөлөгчид эерэгээр үнэлж байв. Тухайлбал, 18 нас хүрсэн Монгол Улсын иргэн бүр сонгуульд оролцож сонгох эрхтэй болохыг хуульчлан баталгаажуулсан. Онолын хувьд сонгуульд оролцохын тулд зөрчилгүй иргэний үнэмлэхтэй байхаас өөр зүйл хуульд тусгагдаагүй. Түүнчлэн иргэд хаяг, байршлын өөрчлөлтөө харьяа орон нутгийн удирдлагад мэдэгдэж иргэний үнэмлэхээ хүчин төгөлдөр байлгасан нөхцөлд тэдний нэрсийг сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдэх бөгөөд бүх сонгогчид сонгууль болохоос өмнө урьдчилж “сонгогчийн үнэмлэх”-ээ хүлээн авах журамтай. (Сонгогчдын нэрсийн жагсаалттай холбоотой асуудлыг “Удирдлагын орчин” дэд хэсэгт хойно илүү дэлгэрэнгүй хэлэлцэж тусгав).

Сонгогчдын оролцоог хангах үүднээс санал авах хугацааг нэлээд урт (өглөөний 7.00 цагаас оройн 22.00 цаг хүртэл) тогтоосон заалт оруулсан байна. Түүнчлэн сонгогчдод “урьдчилан санал” өгөх боломж бүрдүүлэх үүднээс Сонгуулийн өдрөөс 5 хоногийн өмнө хэсгийн хороодын санал авах байрыг нээн ажиллуульж эхлэх тухай төдийлөн түгээмэл бус заалтыг хуульд тусгажээ.

Урьдчилан санал өгөх хугацаанд саналаа өгөхийн тулд сонгогчид харьяа хэсгийн хороон дээр иргэний үнэмлэх, сонгогчийн үнэмлэхээс гадна Сонгуулийн өдөр саналаа өгөх боломжгүй болсон хүндэтгэх шалтгааныг тодорхойлсон гарын үсэг бүхий баримт бичиг авч очих шаардлагатай. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд одоогоор тусгагдаагүй байгаа шуудангаар санал өгөх хэлбэрийг энэхүү журмаар орлуулсан байна. Эрүүл мэндийн шалтгаанаар санал авах байранд биечлэн ирж чадахгүй сонгогчдод хуулийн дагуу зөөврийн саналын хайрцгаар санал өгөх нөхцийг бүрдүүлсэн.

Сонгогчдын нэрсийн жагсаалт гарснаас хойш эрүүл мэнд, албан ажлын хүндэтгэх шалтгаанаар шилжсэн сонгогчдод сонгуульд оролцож санал өгөх боломжийг хуулиар хангаж өгсөн. Хүндэтгэх шалтгаанаар шилжих шаардлага гарсан сонгогч харьяа хэсгийн хороон дээр очиж нэрээ сонгогчдын нэрсийн жагсаалтаас хасуулахын сацуу холбогдох шилжүүлэг авч, улмаар шилжиж очсон газрын сонгуулийн хэсгийн хороонд саналаа өгөх боломжтой. Ийм сонгогчид иргэний үнэмлэхийн хамт зохих “шилжүүлэг”-ээ хийлгэсэн сонгогчийн үнэмлэхээ хэсгийн хороонд авч очсоноор санал өгөх эрхтэй бөгөөд шилжин ирсэн сонгогчийг тухайн хэсгийн хороо тусад нь нэрсийн жагсаалт гарган бүртгэж, саналын хуудсыг тусгай хайрцганд хийлгэж тусад нь тоолох учиртай.

#### Олон нийтийн ба хувийн өмчит хэвлэл мэдээллийн хэрэгсэл

УИХ-ын Сонгуулийн тухай хуульд бүх нам, эвсэл, бие даан нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгааг олон нийтийн радио, телевизээр үнэ төлбөргүй дамжуулах боломж бүрдүүлсэн. Хуульд зааснаар СЕХ олон нийтийн радио телевизийн сурталчилгааны цагийг тэнцвэртэй хуваарилах үүрэгтэй. Төлбөртэй зар сурталчилгааг хувийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулахыг зөвшөөрсөн ч хуулиар

хувийн радио, телевизийн нийт нэвтрүүлгийн хугацааны 10-аас дээш хувийг улс төрийн зар сурталчилгаанд хуваарилахыг хориглосон байна. Нам, эвслийн албан ёсоор бүртгүүлсэн мөрийн хөтөлбөрөөсөө хальсан улс төрийн сурталчилгаа хийхийг улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдэд хориглосон нэлээд сонирхолтой гэмээр түгээмэл бус заалт хуульд тусгагдсан байна.

Олон нийтийн ба хувийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай дээрх заалтуудын хэрэгжилтэд хяналт тавих хэвлэл мэдээллийн бие даасан зөвлөлийг СЕХ-ноос байгуулах тухай хуульд заажээ. Хэвлэл мэдээллийн бие даасан зөвлөл байгуулсан, мөн холбогдох нөөц хөрөнгө хуваарилсан эсэх талаар баттай мэдээлэл цуглуулах бололцоо ажиглагчдад гараагүй. Төлөөлөгчдийн мэдэж байгаагаар тус зөвлөл өөрийн хийсэн ажил, ажигласан зүйлсийн талаар дүгнэлт, тайлан мэдээ гаргаагүй болно. Харин дотоодын “Globe International” ТББ-ын хийсэн мониторингийн үр дүнгээс үзвэл хэвлэл мэдээллийн ашиглалт ерөнхийдөө хуулийн хүрээнд зохистой хангагдаж байсан ажээ.

### Санхүүгийн хяналт ба тайлагнах механизм

УИХ-ын Сонгуулийн тухай хуульд зааснаар СЕХ-ноос улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын хязгаарыг 26 тойрог тус бүрээр хүн ам, мандатын тооноос хамааруулж тогтооно. СЕХ-ны зохицуулалтаар хамгийн том тойрогт өрсөлдөх нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дээд хязгаарыг 435000 ам.доллараас, хамгийн жижиг тойрогт 115000 ам. доллараас хэтрэхгүй байхаар тус тус тогтоосон. Улс төрийн нам, эвслийн сонгуулийн зардлыг 26 тойргоор авч үзвэл 226000-870000 ам.доллар байхаар харилцан адилгүй хязгаартай тогтоожээ.

Сонгуулийн тухай хуульд хувь хүмүүс, аж ахуйн нэгжээс улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдэд өгөх хандивийн

хэмжээнд мөн хязгаар тогтоосон. Хувь хүмүүсээс өгөх хандив 875 ам. доллар, компани ба аж ахуйн нэгжийн хандив 2,600 ам. доллараас хэтрэхгүй байхаар тус тус тогтоожээ. Сонгуулийн тухай шинэ хуулийн дагуу СЕХ-нд албан ёсоор бүртгүүлэх гурав хоногийн хугацаанд нэр дэвшигч банкинд тусгай данс нээж, СЕХ-нд данс нээсэн тухай мэдэгдэл, дансны талаарх бусад мэдээллийг хүргүүлнэ. Сонгуулийн зардлыг энэхүү сонгуулийн дансаар дамжуулж зарцуулах бөгөөд СЕХ нь Монгол Банктай хамтран сонгуулийн зардлын зарцуулалтын талаар мэдээлж тайлагнах, мөн дансны гүйлгээг хянах журам бүрдүүлэх шаардлагатай. Улс төрийн нам, эвсэл болон нэр дэвшигчид сонгуулийн зардлын тайланг 2008 оны 7 дугаар сарын 31-ний дотор СЕХ-нд хүргүүлэхээр заасан.

Хэвлэл мэдээллийн зөвлөл, түүний хяналт тавих чиг үүрэгт зориулж хуваарилсан хөрөнгө төсөв, мөн СЕХ, Монгол Банк хяналт зохицуулалт хийх үүрэг хариуцлагыг ямар түвшинд гүйцэтгэсэн зэргийг нягтлах бололцоо АНДАТТ-ийн ажиглагчдад гараагүй.

### Сонгуулийн удирдлага

Хуулиар бүрдүүлсэн сонгуулийн байгууллагын санал авах, сонгуулийн дүн нэгтгэж гаргахад чиглэсэн суурь орчин, дүрэм журам нь зохих ёсоор бодитой хангагдсан төдийгүй бусад орнуудад түгээмэл байдаг цаасаар санал авах сонгуулийн системтэй ерөнхийдөө нийцэж байв.

Сонгуулийн өмнөх олон нийтийн санал асуулга, хэвлэл мэдээллийн байгууллагын мэдээнээс үзвэл СЕХ-нд итгэх итгэл сулавтар байсан хэдий ч СЕХ хүлээсэн үүрэг хариуцлагаа гүйцэтгэх явцад ноцтой алдаа гаргасан гэх зүйл ажиглагдаагүй. СЕХ-ны хүрээнд ажиллах зохион байгуулалтын нэгж хороодыг хугацаанд нь байгуулж, сонгуулийн чухал шаардлагатай материалуудыг цаг

хугацаанд нь багтаж бэлтгэн хүргүүлсэн болох нь ажиглагдсан.

Сонгуулийн өдрөөс өмнө АНДАТТ-ийн төлөөлөгчид сонгуулийн тойргийн болон хэсгийн хороодод очиж ажиглах явцад, хороод зохих ёсоор хугацаандаа бүрэн байгуулагдсан байв. Хэсгийн хороодын ихэнх гишүүд (бүгд бус) зохих сургалтад хамрагдсан талаар хэлж байсан бөгөөд тухайн хэсгийн хороодын санал авах байрны бэлтгэл хангагдсан төдийгүй хуулийн дагуу сонгуулийн өмнөх өдрүүдэд урьдчилсан санал авах ажиллагаа явагдаж байсан.

### Сонгуулийн Ерөнхий Хороо

СЕХ нь Улсын Их Хурлаас олгосон эрхийн дагуу тус улсад сонгууль зохион байгуулах ерөнхий чиг үүрэгтэй байгууллага юм. СЕХ нь есөн гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд УИХ-аас зургаан жилийн хугацаатай томилогддог. УИХ-ын Сонгуулийн тухай хуульд зааснаар УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооноос 5, Монгол Улсын ерөнхийлөгч 2, Дээд Шүүхээс 2 гишүүнийг тус тус томилно. СЕХ-ны дарга, нарийн бичгийн даргыг УИХ-ын даргын саналыг үндэслэж томилохоор заасан.

СЕХ-ны үндсэн гол үүрэг хариуцлагаас дурдвал: улсын хэмжээн дэх 26 тойрог бүрт Сонгуулийн Тойргийн Хороо байгуулж бүрэлдэхүүнийг батлах, сонгуулиас өмнө сонгуулийн тойргийн хороодод сонгуулийн чухал шаардлагатай баримт материал болон төсөв хөрөнгийг хуваарилж хүргүүлэх, улс төрийн нам эвсэл, нэр дэвшигчдийг бүртгэх, сонгогчдын нэрсийн жагсаалтыг гаргаж тойрог, хэсгийн хороодод хүргүүлэх, саналын хуудсыг хэвлэх ба хуваарилах ажлыг хянан зохицуулах, доод шатны хороодын шийдэх боломжгүй гомдол маргааныг шийдвэрлэх, сонгуулийн албан ёсны үр дүнг нэгтгэж мэдээлэх, УИХ-д шинээр сонгогдсон гишүүдийн нэрсийг Монгол Улсын

Ерөнхийлөгчид өргөн барьж, хэвлэл мэдээллээр олон нийтэд зарлах, сурталчилгааны санхүүжилт буюу сонгуулийн зардлын талаарх сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, олон нийтийн болон хувийн өмчит хэвлэл мэдээллийн хэрэгслээр улс төрийн сурталчилгаа хуулийн хүрээнд явагдаж байгааг хянаж зохицуулах үүрэгтэй.

### Тойрог, салбар, хэсгийн хороод ба санал авах байр

СЕХ-ны удирдлагад ажиллах сонгуулийн 26 тойргийн хороог СЕХ сонгуулийн өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө байгуулсан байх шаардлагатай. Тойргийн хороод дарга, нарийн бичгийн дарга болон 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. СЕХ-ны мэдээлснээр улсын хэмжээнд нийт 286 ажилтан сонгуулийн тойргийн хороодод ажилласнаас АН-ын төлөөлөгч 100, МАХН-ын төлөөлөгч 92 байжээ. АНДАТТ-ийн ажиглагчид сонгуулийн өдөр ба өмнөх өдрүүдэд тойргийн хороодод хийсэн ажиглалттай дээрх тоо мэдээ нь үндсэндээ тохирч байв.

Сонгуулийн тойргийн хороод тухайн дүүрэгт хамаарах сонгуулийн баримт материал болон төсөв хөрөнгийг төлөвлөх, зохион байгуулах, хуваарилж хүргүүлэх үүрэгтэй. Мөн тойргийн хороод хэсгийн хороодоосоо авсан саналын дүнг нэгтгэж, мэдээлнэ. Тойргийн хороод дээрх ажил үүргийг сонгуулийн өдрийн дараахь гурав хоногийн дотор хийж гүйцэтгэн дараагийн хоёр өдөрт нь СЕХ-нд нэгтгэсэн дүнг мэдээлэх ёстой.

Сонгуулийн 26 тойргийн хороод харилцан адилгүй тооны Сонгуулийн тойргийн салбар хороодтой байх бөгөөд, нэг салбар хороо нь дарга, нарийн бичгийн дарга болон 5-7 гишүүд бүхий бүрэлдэхүүнтэй байна. Тойргийн салбар хорооны гишүүд нь тойргийн хороо болон хэсгийн хороод (санал авах байр)-ын харилцан уялдааг хангаж ажиллах үүрэгтэй. Улсын хэмжээнд нийт 333 салбар хороо байгуулагдсан.

Сонгуулийн хэсгийн хороо буюу санал авах байр (хэсэг) нь сонгуулийн удирдлагын бүтцийн суурь нэгж болно. Хэсгийн хороо бүр нэг хэсэг буюу санал авах байрыг хариуцаж ажиллана. Хэсгийн хороо нь дарга, нарийн бичгийн дарга, нийт 9-15 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Хуульд зааснаар хэсгийн хороодыг сонгуулийн өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө байгуулсан байх учиртай. Улс төрийн намууд Сонгуулийн тойргийн хороогоор дамжуулж өөрийн төлөөлөгчдийн нэрсийг дэвшүүлж хэсгийн хороодын гишүүдийг томилно. Сонгуулийн өдөр Монгол Улсын хэмжээнд нийт 1704 хэсгийн хороод (санал авах байр) ажилласан тухай СЕХ-ноос мэдээлсэн.

СЕХ-ны мэдээлснээр улсын хэмжээнд сонгуулийн хэсгийн хороодод нийт 14162 гишүүд ажиласнаас 5673 нь АН-ыг төлөөлж, 5753 нь МАХН-ыг төлөөлж, үлдсэн хэсэг нь бусад нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийг төлөөлж ажиллав. Дээрх тоо мэдээ нь АНДАТТ-ийн ажиглагчид сонгуулийн өдөр ба өмнөх өдрүүдэд хийсэн ажиглалттай нийцэж байна.

Хэсгийн хороод санал авах байр бэлтгэх, сонгогчдын нэрсийн жагсаалтын үнэн бодит байдлыг нягтлах, санал авах ажлыг зохион байгуулах, саналын хуудас тоолох, сонгуулийн дүнг тэмдэглэж нэгтгэх, нэгтгэсэн дүнг харьяа тойргийн хороо буюу салбар хороонд мэдээлэх зэрэг ажлыг хариуцан гүйцэтгэнэ. Хуульд зааснаар хэсгийн хороод нь санал тоолох үйл ажиллагааг Сонгуулийн өдөр эцэслэн дуусгах шаардлагатай.

Санал авах байр 22.00 цаг хүртэл ажиллах бөгөөд нэг хэсгийн хороонд бүртгүүлсэн сонгогчдын тоо хэт олон байгаагаас санал тоолох үйл явц удааширч, нүсэр ажил болох магадлалтай талаар АНДАТТ-ийн ажиглагчдын сонгуулийн өмнөх өдрүүдэд очиж уулзсан хэсгийн хороодын гишүүд нийтлэг санал бодолтой байсан. Саналын хуудсыг

завсарлагагүй тоолоод ч хуулиар тогтоосон хугацаанд амжиж дуусгах эсэх тухайд зарим гишүүд эргэлзэж байгаагаа хэлж байв.

### Сонгогчдын нэрсийн жагсаалт

СЕХ болон сонгуулийн бүх түвшний хороодын нэг гол үүрэг хариуцлага нь сонгогчдын нэрсийн жагсаалтыг гаргаж хүргүүлэх, мөн сонгуулийн өдөр нэрсийн жагсаалтын үнэн бодит байдлыг хангаж ажиллах явдал байв. Дэлхийн аливаа улс орны сонгуулийн ямар ч тогтолцоонд нийтлэг байдагчлан, АНДАТТ-ийн төлөөлөгчдийн уулзаж ярилцсан холбогдох хүмүүсийн хувьд сонгогчдын нэрсийн жагсаалтын үнэн бодит, бүрэн гүйцэд байдал нь зүй ёсоор анхаарал татсан асуудал болж байв.

Сонгогчдын нэрсийн жагсаалтыг иргэний бүртгэл мэдээлэл хариуцсан орон нутгийн захиргааны байгууллагын тоо мэдээнд тулгуурлаж гаргана (иргэд 18 нас хүрэхээр иргэний үнэмлэх авдаг). Иргэний бүртгэл хариуцсан орон нутгийн нэгж, ажилтнууд сонгогчдын нэрс, оршин суух хаягийг нэгтгэн харьяа аймаг, дүүргийн засаг даргын тамгын газар хүргүүлнэ. Энэхүү мэдээллийг Иргэний Бүртгэл, Мэдээллийн Улсын Төвд уламжилж, улмаар тус төв (ИБМУТ) үндэсний хэмжээний иргэдийн мэдээллийн санг бүрдүүлж, сонгуулийн өдрөөс 90 хоногийн өмнө СЕХ-нд хүргүүлэх журамтай. Сонгогчдын нэрсийн жагсаалт гаргах дээрх товлосон хугацааг хангаж биелүүлсэн гэж ажиглагчдад ойлгогдсон. Үүгээр энэ цаг мөчөөс эхлэн улсын хэмжээний иргэний бүртгэлийн мэдээллийн сан нь сонгогчдын нэрсийн жагсаалтын анхны төслийг бүрдүүлэх ажээ.

Сонгуулийн өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө СЕХ-ноос сонгуулийн 26 тойргийн хороодод сонгогчдын нэрсийн жагсаалтыг хүргүүлнэ. СЕХ сонгогчдын нэрсийн жагсаалтыг эвб хуудаст байрлуулж, нам эвсэл болон сонгогч иргэдэд

нээлттэй ил тод болгоно. Иргэд зөвхөн өөрийн нэрийг шалгаж танилцах боломжоор хангана.

Тойргийн хороод сонгогчдын нэрсийн жагсаалтыг сонгуулийн өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө харьяа хэсгийн хороодод хүргүүлнэ. Нэг хэсгийн хороонд ногдох сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэх сонгогчдын тоог хуульчилсан. Хуулинд зааснаар нэг хэсэг нь суманд 2000, аймгийн төвд 3500, Улаанбаатар хотод 6000 хүртэл сонгогчтой байна. АНДАТТ-ийн олон ажиглагчид дээрх тогтоосон тоо хэмжээг хэт өндөр болохыг тэмдэглэж байсан бөгөөд сонгогчдын нэрсийн жагсаалтад маш олон сонгогчид бүртгэгдсэнээс үүдэн санал тоолох, сонгуулийн дүнг мэдээлэх ажил хэт удааширч, хүндрэл гарах гол хүчин зүйл болсон гэдэг дүгнэлтэд ажиглагчид хүрсэн.

Тойргийн хорооноос гаргаж өгсөн сонгогчдын нэрсийг хүлээн авсны дараа хэсгийн хороод үнэн бодит байдлыг нягтлан шалгах үүрэгтэй. Энэ ажлыг хэсгийн хороодын гишүүд айл өрх бүрээр очиж сонгогчдын нэрсийн жагсаалтыг тулгах байдлаар хийсэн гэж ойлгогдсон. Хаяган дээрээ байхгүй иргэдийн нэрсийг сонгогчдын нэрсийн жагсаалтаас хасч, харин нэрсийн жагсаалтад нэр нь бүртгэгдээгүй ч хүчин төгөлдөр иргэний үнэмлэхтэй иргэдийг жагсаалтад нэмсэн байв. Хэсгийн хороод нягталж эцэслэсэн нэрсийн жагсаалтыг сонгуулийн өдрөөс 15-аас доошгүй хоногийн өмнө өөрийн байранд ил тавьж, нийтэд чөлөөтэй танилцах бололцоо олгох ёстой. Дээрх шаардлага, тогтоосон хугацааг зохих ёсоор хангаж хэрэгжүүлсэн болох нь АНДАТТ-ийн төлөөлөгчдөд ажиглагдсан. Сонгогчийн нэрийг зохих ёсоор нэрсийн жагсаалтад тусгаагүй нөхцөлд сонгогчид харьяа тойргийн хороонд гомдол гаргах эрхтэй.

Сонгогчдын нэрсийн жагсаалтыг тулгаж нягталсны дараа хэсгийн хороодын нягталсан нэрсийн жагсаалтад нэр нь

бүртгэгдсэн сонгогчдод сонгогчийн үнэмлэх хүргэж өгнө. Ажиглагчдын олж авсан мэдээллээс үзвэл, сонгогчийн үнэмлэхийг хэсгийн хороодын гишүүд харьяа нутаг дэвсгэрийнхээ айл өрхөөр биечлэн очиж тараахаас гадна шуудангаар явуулах, сонгогчид өөрсдөө ирж авах зэрэг арга замаар олгожээ. Сонгогчид саналаа өгөхийн тулд иргэний үнэмлэх, сонгогчийн үнэмлэхээ үзүүлэн, сонгогчдын нэрсийн жагсаалт дахь өөрийн нэрийн ард гарын үсгээ зурж саналын хуудас авах эрхтэй. Ажиглагчдын сонсож мэдсэн ихэнхдээ нотолгоо багатай мэдээллээр, сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын дийлэнх нь сонгуулийн өдрөөс өмнө сонгогчийн үнэмлэхээ авсан ч сонгогчийн үнэмлэхээ урьдчилж аваагүй сонгогчид ч нэлээд байсан ажээ. Сонгуулийн өдөр санал авах байранд олон иргэд сонгогчийн үнэмлэхээ авч байсныг ажиглагчид олж харснаар дээрх мэдээлэл батлагдсан юм.

АНДАТТ-ийн ажиглагчдын ажиглалт болон холбогдох талуудтай хийсэн уулзалтаас үзвэл, сонгогчдын нэрсийн жагсаалтыг бүрдүүлэх явцад системтэйгээр ноцтой зөрчил гаргасан, дүрэм журмыг гажуудуулсан буюу үүнээс үүдэн сонгуулийн өдөр ашигласан нэрсийн жагсаалтыг үнэн зөв гаргасан гэдэгт эргэлзэхэд хүргэсэн баримт нотолгоо аваагүй болно. Гэхдээ тэд сонгогчдын нэрсийн жагсаалтыг гаргах ажил болон сонгогчдын сонгогчдын нэрсийн жагсаалтын эцсийн хувилбарыг гаргах явц ихээхэн учир дутагдалтай явагдсан байж болзошгүй гэж онцлож байсан.

Тухайлбал Улаанбаатар хот, Орхон аймагт ажилласан ажиглагчдын мэдээлснээр тойрог, хэсгийн хороодод хүргүүлсэн нэрсийн жагсаалтад томоохон хэмжээний засвар хийгдсэн байв. Улаанбаатар хот дахь УИХ-ын сонгуулийн 23 дугаар тойрогт сонгогчдын нэрсийн жагсаалтыг тулгаж нягтлах явцад сонгогчдын тоо 54000-аас 70000-ын хооронд хэлбэлзэж байгаад 64000 болж эцэслэгдсэнийг АНДАТТ-ийн

төлөөлөгчид ажигласан. Үүнээс үзвэл Иргэний Бүртгэл, Мэдээллийн Улсын Төв болон СЕХ-ноос хүргүүлсэн анхны жагсаалтад бүртгэгдсэн нэрсийн 20 хүртэлх хувь нь бодит бус байсан гэж үзэхээр байна. Орон даяар хүн амын шилжилт хөдөлгөөн нэлээд өндөр төдийгүй шилжин суурьших иргэд харьяа нутаг дэвсгэрийнхээ холбогдох бүртгэл мэдээлэлд нэрээ зохих ёсоор хасуулж, бүртгүүлдэггүйгээс ихэнх зөрчил гардаг ажээ.

Түүнчлэн дээрх хугацаанд их хэмжээний засвар хийгдэж байгаагаас үзэхэд сонгуулийн өдөр хэрэглэх албан ёсны нэрсийн жагсаалт нь сонгуулийн өдрөөс өмнөхөн хэсгийн хорооны гишүүдийн хийж дуусгасан ажлын үр дүн болж байгаа нь түвэгтэй байдлыг бий болгож байна. Нэг тохиолдлыг авч үзэхэд, Улаанбаатар хот дахь УИХ-ын сонгуулийн 26 дугаар тойрогт тухайн нутаг дэвсгэрийн нэг ажилтан тус дүүрэгт амьдардаг нэрийдлээр 30 хүний нэрийг сонгогчдын жагсаалтад санаатайгаар нэмж оруулахаар завдаж байхтай АНДАТТ-ийн ажиглагчид тааралдсан ажээ. Зөрчил доголдол харьцангуй бага, залруулж болохуйц түвшинд байсан ч сонгогчдын нэрсийн жагсаалтын найдваргүй сул тал нь дээрх эцсийн шатанд санаатай гажуудуулж ашиглах боломжтойг илтгэж байна.

Монгол орны хөдөө нутгаас хот суурин руу шилжих хөдөлгөөн өндөр байгаагаас улбаалан сонгогчдын нэрсийн жагсаалтын үнэн бодит байдлыг тулгаж нягтлах нь бодитой тулгамдсан асуудал болж байна. Үүнээс үүдэн Монгол Улсын төр засгийн удирдлага сонгогчдын нэрсийн жагсаалтыг найдвартай бүрдүүлж, бодит байдлын хангах талаар альтернатив арга хувилбар нэн тэргүүнд олж судлах нь зүйтэй.

### **III. Сонгуулийн өдөр ба санал тоолох үйл явц**

Сонгуулийн өдөр – 2008 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсын нэг сая орчим иргэн сонгуульд оролцсонд АНДАТТ-ийн төлөөлөгчид сэтгэл ханамжтай байгаагаа өмнөх Урьдчилсан мэдэгдэлд дурдсан билээ. Ажиглагчдын очсон бүх хэсгийн хороодын санал авах байранд сонгогчдын ирц өндөр байв. Энэ нь Монгол Улсын иргэд эх орныхоо улс төрийн шийдвэр гаргах үйл явцад оролцох идэвх өндөр байгааг харуулж буй хэрэг юм. Мөн Монгол Улсын ардчиллын эрч хүч, цог золбоог илтгэх бодит нотолгоо төдийгүй цаашид улам дэвжихийн илэрхийлэл билээ.

СЕХ, түүнчлэн АНДАТТ-ийн ажиглагчдын хуваарилагдан очиж ажилласан тойргийн болон хэсгийн хороод сонгуулийн өмнөх бэлтгэл ажил, үүнд сонгогчдын нэрсийн жагсаалт, саналын хуудас, бусад шаардлагатай материалыг хуулинд заасан хугацаанд бэлтгэж, хуваарилах ажлыг зохистой гүйцэтгэсэн болох нь харагдсан. Ялангуяа АНДАТТ-ийн төлөөлөгчдийн очиж ажиглалт хийсэн санал авах байрыг хариуцан ажиллаж байсан хэсгийн хороодын бэлтгэл, идэвх зүтгэлийн талаар төлөөлөгчид эерэг сэтгэгдэлтэй байсан. АНДАТТ-ийн хэд хэдэн ажиглагч сонгуулийн хэсгийн хороодын бүрэлдэхүүнд эмэгтэй гишүүд олон байгааг онцлон сайшааж буйгаа илэрхийлсэн билээ.

Сонгуулийн хэсгийн хороод хуулиар тогтоосон цагт нээгдэж, хаагдсан бөгөөд сонгуулийн өдрийн турш сонгогчдын ирц өндөр, сонгуулийн хэсгийн хороодын ажлын зохион байгуулалт сайн байсныг төлөөлөгчид тэмдэглэж байв. Сонгогчид сонгуульд дэг журамтай, идэвхтэй оролцож байсан. Олон мандаттай томсгосон тойрог бүхий сонгуулийн шинэ тогтолцоонд сонгогчдод саналын хуудсаа хэрхэн бөглөх талаар бэрхшээл бага тулгарч байгаа нь ажиглагдсан. Тухайн тойрогтоо хэдэн нэр дэвшигчдийн төлөө санал өгөхийг

зааварчилсан анхааруулгыг саналын хуудсанд оруулах СЕХ-ний шийдвэр дээрх бэрхшээлийг даван туулахад зохих үр дүнгээ өгсөн.

АНЦАТТ-ийн ажиглагчдад сонгуулийн үйл ажиллагааны үндсэн горимд эргэлзэхээр ноцтой зөрчил, гажуудлын шинж тэмдэг ажиглагдаагүй ч сул талууд харагдсан. Тухайлбал нэг хэсгийн хороонд ногдох сонгогчдын нэрсийн жагсаалтад хэт олон сонгогч бүртгэгдсэн, үүнээс улбаалан санал тоолох, сонгуулийн дүн мэдээлэх ажил хэт удааширсан явдал нь бэрхшээл учруулсан гэж ажиглагчид дүгнэсэн. Дээрх болон бусад анхаарал татсан асуудлыг хэлэлцэж дор тусгав.

#### ***А. Санал авах байр, орчин ба бэлтгэл***

АНЦАТТ-ийн төлөөлөгчдийн ажилласан санал авах байр бүр өглөө 07.00 цагт буюу 07.00 цаг орчимд санал авах ажиллагааг эхэлсэн бөгөөд тэнд сонгогчдын санал авах бэлтгэл бүрэн хангагдсан байв. Энэ нь орон даяар нийтлэг байсан гэдэгт бид итгэлтэй байна.

Ажиглагчдын очсон бүх санал авах байрны гадаа цагдаагийн ажилтнууд байсныг тэмдэглэж байв. Цагдаагийн ажилтнууд санал авах байр луу байнга орж гарч байсан ч эмх замбараагүй байдал үүссэнээс тэд санал авах байр луу орсон буюу цагдаагийн болон хамгаалалтын албаны ажилтнууд санал авах ажилд саад учруулсан, учруулахыг завдсан гэх үйлдэл төлөөлөгчдөд ажиглагдаагүй.

Санал авах байрны дотор ба гадна талд нөхцөл байдал ерөнхийдөө тайван, дэг журамтай байсан. Зарим нэг тохиолдолд сонгогчид нэг зэрэг олноороо ирснээс үүдэн яльгүй бухимдал үүсч байсан ч дэг журам алдагдах байдалд хүрээгүй. Санал авах байр орчимд санал өгөхийн өмнө ба дараа иргэд олноор бөөгнөрсөн харагдсан ч санал авах байрны

дотор ба гадна байсан сонгогчдод түвэг учруулах, тэдэнд нөлөөлөх гэсэн аливаа оролдлого ажиглагдаагүй болно.

Сонгуулийн өдөр санал авах байрны ойр орчинд сурталчилгааны материал байрлуулсан эсвэл сурталчилгаа явуулсан зүйл ажиглагдаагүй.

Гэвч зарим санал авах байранд ажиллаж байсан улс төрийн нам, эвслийн ажиглагчид өөрсдийн өрсөлдөгчдийг сонгогчдын саналыг худалдан авах зорилгоор сонгогчдод мөнгө санал болгож байсан тухай АНДАТТ-ийн ажиглагчдад хэлж байсныг тэмдэглэх нь зүйтэй. Манай ажиглагчид ийм зөрчлийг нотлох баримтыг олж аваагүй болно.

Санал авах байрны байршлыг сонгогчдод тодорхой, очиход хялбар газар тогтоосон төдийгүй тухайн нутаг дэвсгэрийн иргэд санал авах байрыг түвэггүй сайн мэдэж байв.

Ажиглагчдын очиж ажилласан санал авах байрыг ихэнх тохиолдолд тухайн орон нутгийн дунд сургуулийн барилга байгууламжид засч бэлтгэсэн байв. Ийм газрууд ерөнхийдөө нэлээд зохимжтой ч бусад төрлийн барилга байшинд байршуулсан нь цөөнгүй байв. Дээрх байшин барилгын чанар харилцан адилгүй байсан бөгөөд нэлээд нь байршлын хувьд зохих дэд бүтэц дутагдалтайгаас санал өгөх үйл явцад зарим талаар хүндрэл гарч байсан. Зарим хэсгийн хороонд хэт олон сонгогч хуваарилагдсан, мөн сонгогчид олноор ирж санал өгөх үеэр олон ажиглагчид зэрэг ажиглах нөхцөлд санал авах байрны багтаамж хангалтгүй байв.

Санал авах байрын дотоод тохижилтыг зохион байгуулах нэгдсэн хэв маяг байхгүй нь харагдсан. Ихэнх тохиолдолд хэсгийн хороодын гишүүд тухайн барилга байшингийн бүтцэд тохируулж санал авах байрны хэлбэр загварыг энгийн байдлаар засч бэлтгэсэн нь ажиглагдсан.

Хэд хэдэн газарт санал авах байр үер усны аюулаас урьдчилан сэргийлэх шаардлага хангаагүй нь харагдсан. Тухайлбал, Хэнтий аймгийн төв Өндөрхаан хотод сонгууль болохын өмнөхөн үер уснаас сэргийлж нэлээд хэдэн санал авах байрыг нүүлгэн шилжүүлэхэд хүрсэн. Улаанбаатар хотын захын зарим дүүрэгт ширүүн бороо орсноос санал авах байр луу очих замын хөдөлгөөн саатаж, улмаар санал өгөх үйл явц тасалдсан тохиолдол гарсан.

Маш цөөн тохиолдлыг эс тооцвол, санал авах байр бүр өглөө 07.00 цагт нээгдэж, сонгуулийн өдрийн туршид сонгуулийн хэсгийн хороод бүрэн бүрэлдэхүүнээр ажил үүргээ гүйцэтгэж байсан гэж ажиглагчид мэдээлсэн. АНДАТТ-ийн ажиглагчид очиж ажиглах явцад санал авах байранд ажиллаж байсан хэсгийн хорооны ихэнх гишүүдийн хууль эрх зүйн ойлголт, мэдлэгийг онц сайн буюу сайн түвшинд, харин цөөн хэсгийг дунд зэрэг гэж дүгнэсэн.

АНДАТТ-ийн бараг бүх ажиглагчид сонгуулийн хороодын дарга ба нарийн бичгийн дарга (нэлээд нь эмэгтэй) нарын мэргэжлийн ур чадварт ерөнхийдөө эерэг сэтгэгдэлтэй байсан ч зарим нэг гишүүд ажиглагчидтай найрсаг бус харьцсан талаар цөөн тооны ажиглагчид мэдээлсэн. Нэлээд хэдэн санал авах байранд сонгогчид олноор ирж санал өгөх үеэр хүндрэл гарч байсан ч хэсгийн хороодын гишүүд сонгогчдын хөл ихтэй урсгалыг зохицуулах талаар ерөнхийдөө сайн ажиллаж байсан.

Холбогдох баримт материал хугацаа хоцорсон буюу үүнээс үүдэн санал өгөх, тоолох үйл явц саатсан гэх тохиолдлын талаар ажиглагчдад мэдээлээгүй. Гэвч АНДАТТ-ийн ажиглагчдад зарим хэсгийн хороод сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын нийт тооноос цөөн саналын хуудас хүлээж авсан тухай мэдэгдсэн. СЕХ-ны зохицуулалтаар нэрсийн жагсаалтад орсон сонгогчдын

тооноос 10% илүү саналын хуудас захиалж авахыг даалгасан. Сонгогчдын ирц 100% байсан буюу саналын хуудас дутсан нэг ч тохиолдол гараагүй. Ялангуяа хот суурин газрын ихэнх хэсгийн хороодод сонгогчдын тоо нэлээд олон байгаа нөхцөлд 10%-ийн саналын хуудасны нөөц нь хэтэрхий ихэдсэн, нийт саналын хуудасны найдвартай байдлыг хангахад хүндрэл гарч болзошгүй гэж АНДАТТ-ийн хэд хэдэн ажиглагчид үзэж байв.

## **Б. Санал авах үйл явц**

АНДАТТ-ийн ажиглагчдын очиж ажигласан 100 гаруй санал авах байранд үйл ажиллагаандаа мөрдлөг болгох нэгдсэн журам дутагдалтай байгааг ажигласан төдийгүй тухайн хэсгийн хорооны саналын дүнд бодитой нөлөөлж болзошгүй доголдлын талаар хоёр тохиолдлыг мэдэгдсэн. Гэвч системтэйгээр үйлдсэн зөрчлийн шинж тэмдэг, дүрэм журмыг санаатай зөрчсөн үйлдэл, түүнийг тодорхой нэр дэвшигчид буюу намуудад ашигтай байх үйлдлийн оролдлого гэж үзэхээр ямар ч зүйл АНДАТТ-ийн ажиглагчид олж хараагүй.

Сонгуулийн өдөр сонгогчдын нэрсийн жагсаалт нь ноцтой, томоохон зөрчлийн эх үүсвэр болсон гэх нотолгоо баримтыг хүлээж аваагүй. Сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдээгүй гэх нэрийдлээр зохих ёсны үнэмлэхтэй сонгогчдыг буцаасан маш цөөн тохиолдлын талаар АНДАТТ-ийн ажиглагчид мэдээлсэн. Тэдгээр сонгогчдыг харьяалагдах өөр хэсгийн хороонд очиж саналаа өгөхийг зааварчилж байв. Ийм нийтлэг сэгтгэгдлээс өөр зөрчилтэй асуудлын талаар хэсгийн хорооны гишүүд, ажиглагчид мэдээлээгүй.

Гэвч үүний зэрэгцээ санал авах байранд үүсэх сонгогчдын урт дараалал, хэт бөөгнөрөл нь хэсгийн хороодод олон сонгогч хуваарилсантай холбоотой гэж ажиглагчид дүгнэсэн.

Түүнчлэн хэт олон сонгогч бүртгэгдсэн нэрсийн жагсаалтаас үүдсэн ноцтой сөрөг үр дагавар санал тоолох явцад гарах нь илт харагдаж байв.

Хэсгийн хороодын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын тоо хот суурин газруудад харилцан адилгүй байв. Улаанбаатар хотод нэг хэсгийн хорооны жагсаалтад 6000 сонгогч, аймгийн төвүүдэд 3500 сонгогч байхаар хуулиар тогтоосон. Бодит байдалд нэрсийн жагсаалт дахь сонгогчдын тоо дээрх хэмжээнээс нэлээд бага байсан ч ерөнхийдөө ихэдсэн хэвээр байв. Улаанбаатар хотод АНДАТТ-ийн төлөөлөгчид очиж ажигласан хэсгийн хороодын нэрсийн жагсаалтад дунджаар 3650 сонгогч бүртгэгдсэн байв. Тухайлбал, хамгийн том хэсгийн хорооны нэрсийн жагсаалтад 5400 сонгогч бүртгэгдсэн байжээ. Орон нутагт аймгийн төвийн хэсгийн хороодын нэрсийн жагсаалтад дунджаар 1960 сонгогч бүртгэгдсэн байсан бөгөөд хамгийн том хэсгийн хорооны нэрсийн жагсаалтад 3265 сонгогч бүртгэгджээ.

АНДАТТ-ийн төлөөлөгчид аймгийн төвөөс гадагш ердөө таван суманд очиж ажиглалт хийсэн бөгөөд сумдын хэсгийн хороодын нэрсийн жагсаалтыг 2000 сонгогчоор хязгаарласан байв. Ажиглалт хийсэн сумын хэсгийн хороодод сонгогчдын нэрсийн жагсаалтад дунджаар 400 сонгогч бүртгэгдсэн байжээ. Ажиглагчдын очиж ажигласан сумдын санал авах байрны тоо цөөн байгаа тул энэ нь аймгийн төвөөс гадна орших сумдын хэсгийн хорооны нэрсийн жагсаалтыг ерөнхийд нь илтгэх боломжгүй.

Ерөнхийдөө сонгогчдын баримт бичгийг нягтлах, сонгогчдын санал өгөх эрхийг бүрдүүлэх талаар хэсгийн хорооны гишүүд хуульд заасны дагуу яв цав биш гэхэд зохих арга хэмжээг авч байсан гэж АНДАТТ-ийн гишүүд дүгнэсэн. Санал өгөх эрх нь зохих ёсоор хангагдаагүй нэлээд олон

сонгогчдод тодорхой хэсгийн хороодод санал өгүүлсэн, эсвэл үйл ажиллагааны хайхрамжгүй байдлаас их хэмжээний саналыг ноцтой эрсдэлд хүргэсэн гэж сэжиглэхээр үндэслэл ажиглагчдад харагдаагүй байна.

Хэсгийн хорооны санал авах байранд ирсэн сонгогчдын дийлэнх нь хуульд заасны дагуу иргэний үнэмлэх, сонгогчийн үнэмлэхтэй ирсэн болох нь харагдсан. Тэд сонгогчдын нэрсийн жагсаалтаас нэрээ олж, нэрнийхээ ард гарын үсгээ зурсны дараа саналын хуудсыг авч байсан. Шилжин ирсэн сонгогчид иргэний үнэмлэх дээрээ шилжсэн шалтгааныг тодорхойлсон шилжүүлэг авч ирсэн байв. Тэдний нэрсийг тусад нь бэлтгэсэн жагсаалтад бүртгэж байлаа. Хуульд заасны дагуу тусад нь бэлтгэж лацадсан жижгэвтэр хайрцагт шилжин ирэгсэд саналын хуудсыг хийж байсан тухай ажиглагчид мэдээлсэн. Шилжин ирсэн сонгогчдын тоо хэвийн бус гэж үзэхээр нэг ч тохиолдлыг манай төлөөлөгчид ажиглаагүй.

Сонгогчид сонгогчийн үнэмлэхгүй ирснээс үүдэлтэй асуудал үе үе гарч байсан. Сонгуулийн өдрөөс өмнө сонгогчийн үнэмлэхийг 100% тараагаагүй буюу хуульд заасны дагуу сонгогчид биечлэн ирж үнэмлэхээ бүрэн аваагүй талаар ажиглагчдын өмнө тэмдэглэж байсан мэдээллийг дээрх зөрчил нотолсон гэж болно. Харин сонгуулийн өдөр хэсгийн хороод дээр маш олон сонгогчид сонгогчийн үнэмлэхээ авч байгаа нь харагдсан. Хэдийгээр хууль журмыг даган мөрдөх гэдэг утгаар авч үзвэл дээрх нөхцөл байдлыг зөрчил гэж үзэж болох ч тэдгээр иргэдийн нэрс сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн, мөн тэдний бүртгэлтэй хаяг нь иргэний үнэмлэхтэй тохирч байсан зэрэг зохих шаардлагыг хангаж байсан тул ажиглагчид дээрх асуудлыг онцгойлж зөрчил гэж үзээгүй болно.

Зарим хэсгийн хороодод ажиглагчид, мөн АН болон бусад намын лидерүүдийн зүгээс хэлж байсан болзошгүй гэмээр ноцтой асуудал бол сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэлгүй МАХН-ын дэмжигчдэд хуурамч иргэний үнэмлэхээр сонгогчийн үнэмлэх олгосон гэх таамаг яриа гарч байв. Нэрсийн жагсаалтад бүртгэлгүй иргэдийг сонгогчдын нэрсийн жагсалтад нэмж бичин санал өгүүлсэн буюу тийм хуурамч үнэмлэхийг орон нутгийн засаг захиргааны ажилтнууд, иргэний бүртгэл мэдээллийн албаны ажилтнууд олгосон гэсэн таамаг яриа сонсогдсон. Хэрэв дээрх асуудал үнэн бол энэ нь тухайн хэсгийн хороод, тойргийн хороодын сонгуулийн дүнд бодитой үр дагавар учруулж болзошгүй ноцтой асуудал юм. Гэвч АНДАТТ-ийн ажиглагчид очиж ажилласан хэсгийн хороодод дээрх мэдэгдлийг батлах баримт нотолгоо ажиглагдаагүй. Түүнчлэн хяналт шалгалтын хэрэгсэл, сонгуулийн явцын ил тод байдал зохих түвшинд хангагдсаныг манай ажиглагчид нүдээр харж ажигласан тул иймэрхүү зөрчил ноцтой, олныг хамарсан байдлаар гарсан гэж үзэх үндэслэл байгаагүй.

Сонгогчид нэгээс дээш тооны хэсгийн хороонд очиж саналын хуудас авах боломжийг хязгаарлах хоёр үндсэн арга хэмжээг авч байсан. Нэгдүгээрт, иргэдийн сонгогчдын үнэмлэхийг санал өгөх байрнаас гараад дахин ашиглаж болохооргүйгээр тамгалж байв. Хоёрдугаарт, сонгогчдын хуруунд арилдаггүй бэх түрхэж байхыг ажигласан. АНДАТТ-ийн ажиглагчдын очсон бүх хэсгийн хороодод сонгогчид саналаа өгөөд, санал авах байрнаас гарахын өмнө дээрх хоёр үе шатыг дамжиж байлаа. Бэх түрхэх үйл ажиллагааг ажиглагчид төдийлөн ач холбогдолтой гэж үзээгүй. Учир нь зарим хэсгийн хороодын гишүүд бүх сонгогчдын хуруунд бэх түрхэж байгаа нь харагдаагүй төдийгүй түрхсэн бэхийг амархан арилгаж болохыг ажиглагчид харсан байна.

Хэд хэдэн хэсгийн хорооны санал авах байранд саналын хуудсыг тэмдэглэх явцад сонгогчийн нууцлал зохих түвшинд хангагдсан эсэхэд ажиглагчид бага зэрэг эргэлзэж байв. Тухайлбал, сонгогчид зориуд тусгаарласан бүхээгт бус харин гурван талт хаалт байрлуулсан ширээн дээр саналын хуудсыг тэмдэглэж байсан. Хаалтуудын хооронд хангалттай зай гаргаж байрлуулсан нөхцөлд нууцлал хангагдаж байсан ч санал тэмдэглэх хаалт, ширээг хэт ойрхон байрлуулсан тохиолдолд нэг сонгогч хаалтан дээгүүр хажуугийн сонгогчийн саналыг харж болохоор байгаа нь ажиглагдсан.

АНДАТТ-ийн төлөлөгчдийн очиж санал авах ажил эхлэхийг ажигласан санал авах байруудад саналын хайрцгийг лацдахаас өмнө хэсгийн хороодын гишүүд, ажиглагчдыг байлцуулан зохих ёсоор шалгаж нягталсан. Ихэнх хэсгийн хороодод саналын хоёр хайрцаг, шилжин ирэгсдэд зориулсан жижгэвтэр бас нэг хайрцаг бэлтгэсэн байв.

Урьдчилан авсан саналыг сонгуулийн өдөр санал авч эхлэхээс өмнө саналын хайрцагт хийж байсан.

Сонгуулийн өдөр ажиглагчдын очиж ажигласан хэсгийн хороодод саналын хайрцгийг зохих ёсоор лацдаж, мөн сонгогчид болон хорооны гишүүд, ажиглагчдад харагдахуйц ил газар саналын хайрцгийг байрлуулсан байсан тухай ажиглагчид мэдээлж байсан. Ажиглагчдын очсон зарим газар саналын хайрцгийг батлагдсан улаан лацаар лацдаагүй байсан бөгөөд түүнээс найдваргүй байж болох материалаар орлуулсан байсныг тэмдэглэн хэлсэн.

Сонгуулийн өдрийн үеэр саналын хайрцгийг нээсэн байж болзошгүй баримт нотолгоог ажиглагчид олж хараагүй төдийгүй хэсгийн хороодын гишүүд, ажиглагчдаас энэ талаар төлөөлөгчдөд мэдээлээгүй болно.

Ажиглагчдын бодлоор саналын хуудасны аюулгүй байдлын талаарх хамгийн анхаарал татсан зүйл бол санал авах ажил эхлэхээс өмнө бүх саналын хуудсанд гарын үсэг зурж, тамга дарсанаар тэдгээрийг хүчин төгөлдөр болгосонд оршиж байв. Хуульд зааснаар энэ ажил нь сонгуулийн хэсгийн хороодын даргын үүрэгт хамаардаг хэдий ч урьдчилан бүх саналын хуудсыг хүчин төгөлдөр болгосноор түүнийг залилан мэхлэх сэдлээр алга болгох, хулгайлах эрсдлийг нэмэгдүүлж болзошгүй гэж үзсэн.

### ***В. Урьдчилсан санал ба зөөврийн саналын хайрцаг***

Урьдчилан санал авах хайрцаг болон мөн сонгуулийн өдөр харьяа хэсгийн хороонд биечлэн очиж санал өгөх боломжгүй сонгогчдод зориулсан зөөврийн хайрцгийг зохисгүй байдлаар ашиглахаар завдсан зөрчлийн баримт нотолгоо АНДАТТ-ийн ажиглагчдад ажиглагдаагүй. Сонгуулийн өмнөх өдрүүдэд АНДАТТ-ийн ажиглагчид нэлээд хэдэн хэсгийн хороонд очиход урьдчилсан санал өгөх хүндэтгэх шалтгаантай иргэдийн саналыг зохих журмын дагуу авч бүртгэн, саналыг битүүмжилсэн дугтуйнд хийгээд найдвартай газар хадгалж байхыг ажигласан.

Сонгуулийн өдөр хэсгийн хороод санал авах ажиллагааг эхлэх үеэр хийсэн ажиглалтын явцад дээрх урьдчилан авсан саналын хуудсыг санал авч эхлэхээс өмнө лацадсан саналын хайрцагт хийсэн тухай ажиглагчид мэдээлсэн. Ихэнх тохиолдолд саналын хуудсыг хуулийн дагуу битүүмжилсэн дугтуйтай нь саналын хайрцагт хийж байсан бол цөөн тохиолдолд саналын хуудсыг дугтуйнаас гаргаж саналын хайрцагт хийж байсан талаар ажиглагчид мэдэгдсэн.

Зөөврийн хайрцагтай холбоотой сэжиг бүхий зөрчил, доголдын талаар баримт нотолгоо ажиглагчдаас мэдээлсэн зүйл байхгүй. Зөөврийн хайрцгийн хамт авч явсан саналын

хуудсын тоо нь хүлээн авч бүртгэсэн өргөдлийн тоотой тохирч байв. Зөөврийн хайрцгийг хэсгийн хорооны хоёроос доошгүй гишүүд авч явсан бөгөөд ихэнх тохиолдолд нэг ажиглагч цуг дагалдаж явсан.

Сонгуулийн өдөр АНДАТТ-ийн төлөөлөгчдийн очиж ажиглалт хийсэн хэсгийн хороодыг авч үзвэл, урьдчилсан саналын тоо Улаанбаатар хотод нийт саналын 1.25%, орон нутгийн дөрвөн аймгийн төвд 1.7%-ийг тус тус эзэлж байв. Зөөврийн хайрцгаар авсан саналын тоо Улаанбаатар хотод нийт саналын 0.5%-ийг эзэлж байсан бол аймгийн төвүүдэд 1% хүрээгүй ажээ. Эдгээр үзүүлэлт хэвийн түвшинд байсан гэж үзэж болохоор байна.

### ***Г. Улс төрийн намын ажиглагчид***

Улс төрийн нам, бие даан нэр дэвшигчдийг төлөөлж нийт 13500 дотоодын ажиглагчид сонгуулийн үйл ажиллагааг ажигласан гэж СЕХ-ноос мэдээлсэн. Үүнээс Улаанбаатарт 2362, хөдөө орон нутагт 11000 гаруй ажиглагчид санал өгөх үйл явцыг ажиглажээ. Сонгуулийн өдөр уулзсан 900 гаруй ажиглагчдын ажил үүргийн талаар АНДАТТ-ийн ажиглагчид сэтгэгдэл өндөр байгаагаа илэрхийлж байсан. Сонгуулийн ажиглагчид бүх санал авах байрт ажиллаж байсан бөгөөд тэдгээрийн ихэнх нь зохих түвшинд бэлтгэгдсэн төдийгүй мэргэжлийн түвшинд ажиллаж байсан нь ажиглагдсан. Ихэнх ажиглагчид БНОУХ-ээс СЕХ-той хамтран гаргасан ажиглагчийн дэлгэрэнгүй гарын авлагатай байгаагаа мэдээлсэн.

АНДАТТ-ийн төлөөлөгчдийн ажилласан бүх хэсгийн хороодод АН болон МАХН-ын ажиглагчид ажиллаж байсан. Саналын хуудас тоолох явц хэт удааширсан нь ажиглагчдын тэсвэр тэвчээр, сонор сэрэмжийг сорьсон амаргүй ажил байсан ч сонгуулийг шударга явуулахад намын ажиглагчид гол үүрэгтэй ажилласныг тэмдэглүүштэй.

Гэвч дотоодын нам бус ажиглагчид илт үгүйлэгдэж байсан. Сонгогчдын итгэлийг даах нам бус, иргэний нийгмийн байгууллагуудын ажиглагчдыг сургалтад хамруулан цаашид сонгуульд ажиглагчаар оролцуулбаас олон нийтийн сонгуулийн үйл явцад итгэх итгэлийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой болохыг АНДАТТ-ийн ажиглагчид санал болгож байна.

### ***Е. Саналын хуудас тоолох ба сонгуулийн дүнг мэдээлэх***

Сонгуулийн үеэр АНДАТТ-ийн ажиглагчид саналын хуудас тоолох, сонгуулийн дүнг зарлах үйл явцын зөвхөн нэгээхэн хэсгийг ажигласан гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. АНДАТТ-ийн нийт ажиглагчид 6 дугаар сарын 30-ны өдрийн өглөө үүрээр санал авах байрнаас гарч явах үед хэсгийн хороодын гишүүд 20 гаруй цаг тасралтгүй ажиллаж байсан ч тооллогын үйл явц дуусах төлөвгүй байсан тухай бүгд мэдээлж байв.

Зарим тохиолдолд санал авах байр 22 цагт хааснаас хойш даруй гурван цаг гаруй хугацаа өнгөрсөн атал санал тоолох ажил эхлэхгүй байсан тохиолдлын талаар ажиглагчид мэдээлсэн. Үүнээс үзвэл, санал авч эхэлснээс хойш даруй 30 гаруй цаг өнгөрчихөөд байсан ч 6 дугаар сарын 30-ны өдрийн үдээс хойш ихэнх хэсгийн хороод санал тоолох ажлаа дуусаагүй үргэлжлүүлж байсан гэж үзэж болохоор байв.

Сонгогчдын ирц өндөр, нэг санал авах байрт ногдох сонгогчдын тоо хэт олон, нэг саналын хуудсанд олон нэр дэвшигчид бичигдсэн зэрэг шалтгаанаас үүдэн санал тоолох, сонгуулийн дүнг мэдээлэх үйл явц удааширч сунжрахад хүрсэн. Энэ бол сонгуулийн үйл явцад гарсан ноцтой дутагдал бөгөөд үүнийг урьдчилан тооцож, засч залруулах шаардлагатай байсан гэж ажиглагчид үзэж байна. Хэт

удааширсан тооллогын явц нь саналын хуудсыг санаатайгаар хүчингүй болгох, тэрчлэн ямар нэгэн зөрчил гарсан гэх эргэлзээ, таамаг, хардлага төрүүлэх сэжүүр болсон байх талтай. Санал тоолох, сонгуулийн дүнг зарлах үйл явц удааширсан нь 6 дугаар сарын 29-ний өдөр болсон УИХ-ын сонгуулийн дараахь харамсалтай нөхцөл байдал үүсэхэд нөлөөлсөн байж болзошгүй.

Гэвч ажиглагчдын очиж ажигласан санал авах байранд санал авах ажиллагааг хаах, саналын хуудас тоолох үйл явц зохих журмын дагуу цэгцтэй явагдсанд ажиглагчид ерөнхийдөө эерэг сэтгэгдэлтэй байв. Санал авах байрыг хаах зааврыг ихэнх тохиолдолд мөрдөж ажилласан. (Хавсралт Е). Санал авах байр хаалгаа барих үед сонгогчдыг санал өгүүлээгүй буцаасан тухай цөөн тохиолдлыг мэдээлж байсан. Ихэнх тохиолдолд хэсгийн хорооны дарга санал авах байрны хаалгыг цоожилж, цагдаагийн ажилтнууд гаднах орчныг зохицуулж байсан ажээ. АНДАТТ-ийн ажиглагчдын очиж ажигласан санал авах байранд зөвшөөрөлгүй гадны хүн байсан тухай мэдээлэл гараагүй.

Санал тоолох, дүн гаргах ажлыг зохион байгуулах зааврын дагуу ашиглаагүй болон хүчингүй болсон хуудсыг тоолж, дахин ашиглахаас сэргийлж ирмэгийг хайчлан, лацдаж найдвартай газар хадгалах ёстой. Санал авах байранд саналын хуудас тоолох ажлыг ажигласан ажиглагчид ноцтой зөрчил гарсан тухай мэдээлээгүй. Хүчингүй болсон хуудас маш бага байсан нь цөөн тооны сонгогчидод зааврыг ойлгох, саналын хуудсыг тэмдэглэхэд бэрхшээл учирч байсан талаарх ажиглагчдын мэдээлэлтэй нийцэж байв.

Саналын хуудас тоолох ажил нь саналын хайрцгийн бүрэн бүтэн байдлыг шалгаж нээх, нийт саналын хуудсыг тоолох, хүчинтэй ба хүчингүй хуудсыг ялгах зэргээр эхэлж байсан. Ерөнхийдөө энэ үе шат түвэггүй жигд явагдсан бөгөөд их

хэмжээний саналын хуудас дутагдсан тохиолдол гараагүй. Гэвч зарим тохиолдолд хэсгийн хорооны гишүүд саналын хуудсыг хүчингүйд тооцохдоо сонгуулийн хуулийн холбогдох заалтыг хэт чангатган мөрдүүлж байсныг АНДАТТ-ийн ажиглагчид мэдээлсэн. Сонгогч саналаа хуульд заасны дагуу дугуйлаагүй, харин хэрээсээр (х) тэмдэглэсэн нөхцөлд хүчингүй гэж саналын хуудсыг тодорхойлж байсан тухай нэг ажиглагч мэдээлсэн. Гэхдээ хуулийн дээрх заалтыг аль нэг талд үйлчилсэн сэдэл, хандлагаар мөрдсөн гэх үйлдэл ажиглагдаагүй.

Манай ажиглагчдын ажилласан СХХ-нд нэр дэвшигчдийн авсан саналыг дуудаж, тэмдэглэх явцад хууран мэхэлсэн ямар нэгэн үйлдэл гарсаныг АНДАТТ-ийн ажиглагчид ажиглаагүй бөгөөд тэнд шаардлагатай хяналт шалгалтын хэрэгсэл бүрдсэн нь харагдсан. СХХ-ны нэг гишүүн саналын хуудсыг шалган, нэр дэвшигчийн авсан саналыг чанга дуугаар дуудаж, нөгөө нэг гишүүн саналыг тэмдэглэн авч байв. СХХ-ны гишүүд саналын хуудсыг уншиж, нэр дэвшигчийн саналын тоог хавтгайд хэрхэн тэмдэглэж байгаа нь хорооны бусад гишүүд, дотоод, гадаадын ажиглагчдад ил тод харагдаж байсан.

Санал тоолох явцыг ажигласан манай ажиглагчдын үзэж байгаагаар хэсгийн хороодын гишүүдийн хооронд бухимдал, зөрчилдөөн гараагүй бөгөөд тэд хамтач сэтгэлгээгээр ажиллаж байгаа нь илт харагдаж байсан. Цөөн тохиолдлыг эс дурдвал, СХХ-нд ил тод байдал алдагдсан болон журам зөрчсөн тухай ямар нэг санал, гомдлыг нам, эвслийн ажиглагчид, хэсгийн хорооны гишүүдээс гаргаагүй.

Зарим хэсгийн хороодод сонгогчдын саналыг буруу тэмдэглэсэн, сонгуулийн дүнг хэсгийн хорооноос тойргийн хороо хүрэх замд саналын хайрцагт саналын хуудас нэмж хийсэн эсвэл саналын хайрцгийг замаас нь сольсон зэрэг

гомдол гарсныг нухацтай, нарийн нягталж шалгавал зохино. АНДАТТ-ийн ажиглагчид нь хязгаарлагдмал хүрээнд цөөн тооны санал авах байранд ажиглалт хийснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй ч тэдний очиж ажилласан газарт СХХ-ны дотоод журмыг зөрчсөн, хяналт, ил тод байдлыг алдагдуулсан зөрчил гарсан гэх зүйлс ажиглагдаагүй болно. Хэрэв сонгуулийн хэсгийн болон тойргийн хороодод МАХН-ын бус төлөөлөгчид, үүнд хороодын гишүүд, намын ажиглагчид шууд хамтарч ажиллаагүй нөхцөлд дээрх зөрчлүүдийг нэлээд нухацтай авч үзэх шаардлага зүй ёсоор гарах байсан гэж АНДАТТ-ийн ихэнх ажиглагчид үзсэн.



#### IV. Зөвлөмжүүд

АНДАТТ-ийн төлөөлөгчдийн ажиглалтад үндэслэн, цаашдын сонгуульд анхаарч үзүүштэй доорх санал, зөвлөмжийг СЕХ болон УИХ-д хандан Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэнгийн зүгээс санал болгон уламжилж байна.

##### **Зөвлөмж #1**

Сонгуулийн нэг хэсгийн хорооны сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэх сонгогчдын тоог цөөлж, шинээр тогтоох нь зүйтэй. Ингэснээр санал авах өдрийн үргэлжлэх хугацааг богиносгож, хамгийн гол нь саналын хуудас тоолох ажлыг бага хугацаанд явуулж дуусгах ач холбогдолтой.

Сонгуулийн хуулийн дагуу нэг хэсгийн хороонд ногдох сонгогчдын тоог Улаанбаатар хотод 6000, аймгийн төвд 3500, сумдад 2000 байхаар тогтоосон зүйл заалтыг өөрчлөх асуудлыг УИХ болон СЕХ авч үзвэл зохино. Хэдийгээр бодит байдалд хэсгийн хороодын нэрсийн жагсаалт тогтоосон дээд хэмжээндээ төдийлөн хүрээгүй ч СХХ-ны нэрсийн жагсаалтад хэт олон сонгогч бүртгэгдсэн байсан гэж АНДАТТ-ийн ажиглагчид үзсэн. Дээрх хязгаарыг олон улсын жишигт ойртуулж, Улаанбаатар хотод 1200, аймгийн төвд 1000, сумдад 800 сонгогч байхаар тооцох боломжтой.

Ингэснээр энэ удаагийн сонгуулиар ажилласан хэсгийн хороодын нийт тоог нэлээд хэмжээгээр нэмэгдүүлэх шаардлага гарах боловч одоогийнхоос хоёр дахин цөөлсөн сонгогчидтой санал авах байрыг хэсгийн хороод илүү үр өгөөжтэй зохион байгуулах боломж бүрдэнэ. Хэсгийн хорооны гишүүдийн зарим нь саналын хуудас тоолох явцад идэвх харьцангуй бага, бүтээлч бус байдлаар оролцож байсан тул хороодын тоог олшруулж, цомхон болгосноор саналын хуудас тоолох ажлыг хурдан шуурхай явуулах боломжтой.

Тухайн орон нутагт хэсгийн хороодын тоог нэмэгдүүлэхдээ 2–3 хэсгийн хороодыг нэг барилга байгууламжид байршуулах асуудлыг авч үзүүштэй. Тухайлбал, санал авах байр болгож ашигласан дунд сургуулийн барилга байгууламжид хэд хэдэн санал авах байр байршуулж болохоор харагдаж байв.

### **Зөвлөмж #2**

Үнэн зөв, бүрэн сонгогчдын нэрсийн жагсаалт гаргах илүү үр өгөөжтэй, найдвартай арга замыг боловсруулах үүрэгтэй олон намын төлөөлөл бүхий шинжээчийн баг бүрдүүлэх асуудлыг УИХ-аас СЕХ-нд даалгавал зохино. Одоогийн нэрсийн жагсаалт гаргах үйл явц нь хянаж нягтлахад түвэгтэй, алдаа гарах магадлал өндөр, нэрийн жагсаалтыг буруугаар ашиглах боломжийг нээсэн сул талтай байна. Сонгуулийн өдрөөс 2 долоо хоногийн өмнө хэсгийн хороодын гишүүд сонгогчдын нэрсийн жагсаалтын бүрэн, үнэн зөв эсэхийг нягтлах нь хэт ахадсан гэмээр үүрэг хариуцлага юм. 2012 оны УИХ-ын сонгуулиар илүү боловсронгуй, шинэ арга замаар сонгогчийн нэрсийн жагсаалтыг гаргах зорилго тавих нь зүйтэй.

Бусад зүйлсээс онцлон хэлэхэд, Иргэний Бүртгэл, Мэдээллийн Улсын Төвийн бэлтгэсэн нэрсийн жагсаалтын оронд өмнөх сонгуульд ашигласан жагсаалтын эцсийн хувилбарт тулгуурлан сонгогчдын нэрсийн жагсаалтыг бүрдүүлэх асуудлыг шинжээчийн баг авч үзэх хэрэгтэй. Өмнөх хоёр удаагийн бүх нийтийн сонгуульд оролцоогүй (санал өгөөгүй) иргэдийг сонгогчдын нэрсийн жагсаалтаас шууд хасах бөгөөд нэр нь хасагдсан иргэд нэрээ бүртгэлд дахин оруулах талаар өөрсдөө санаачлага гаргах ёстой.

Шилжин ирэгсэд харьяа Сонгуулийн Тойргийн Хороонд очиж, нэрээ жагсаалтад оруулахын тулд зохих баримт бичгийг бүрдүүлсэн байвал зохино. Түүнчлэн, дээр дурдсан

саналтай холбогдуулан шинжээчийн баг нь одоо олгож байгаа нэг удаагийн сонгогчийн үнэмлэхийн оронд сонгогчийн зураг бүхий байнгын үнэмлэх бий болгох асуудлыг судлан үзэх хэрэгтэй.

### **Зөвлөмж #3**

Санал авах хугацааг богиносгосноор хэсгийн хороодод сонгуулийн өдрийн дараахь өдрийн 02:00 цагаас өмнө саналын хуудас тоолох, сонгуулийн дүнг мэдээлэх ажлыг эцэслэн дуусгах боломж бүрдэнэ. Санал авах байрыг өглөө 07.00 цагт нээж, орой 20.00 цагт (одоогийнхоос 2 цагийн өмнө) хаах талаар анхаарч үзвэл зохилтой. Энэ жишиг нь олон улсын стандартад нийцэх төдийгүй нэрсийн жагсаалтад бүртгэх сонгогчдын тоог цөөлөх, хэсгийн хорооны гишүүдийн ажлын үр өгөөжийг дээшлүүлэхтэй уялдуулснаар саналын хуудас тоолох, сонгуулийн дүн мэдээлэх ажлыг шуурхай болгох ач холбогдолтой.

### **Зөвлөмж #4**

Дараагийн сонгуулиас өмнө ямар тэмдэглээтэй саналын хуудсыг хүчингүйд тооцох шалгуурын талаар СЕХ тодорхой, үндэслэлтэй удирдамж гаргах нь зүйтэй. Шинэ удирдамжид санал тэмдэглэх тэмдэглэгээг голчилсон зааварчилгааны оронд сонгогчийн хүсэл сонирхлыг нэн тэргүүнд анхаарч үзэх талаар тусгавал зохино. Удирдамжид ямар тэмдэглэгээг хүчингүйд тооцох, тооцохгүй талаар нэлээд хэдэн жишээ тусгаж оруулах хэрэгтэй. Тэдгээр зааварчилгааг санал авах байранд байрлуулж сонгогчдын хүртээл болговол зохино.

### **Зөвлөмж #5**

Санал авах өдрөөс өмнө саналын хуудсыг тамгалан, гарын үсэг зурж хүчин төгөлдөр болгох шаардлагагүй. Саналын хуудсыг сонгогчдод өгөхөөс өмнө тамгалж, гарын үсэг зурах нь илүү зохимжтой. Ийм ажил үүргийг гүйцэтгэхэд хугацаа алдаж удаашруулахгүйн тулд хэсгийн хорооны нарийн

бичгийн дарга, шаардлагатай гэж үзвэл даргад даалгаж болно. Одоогийн жишгээр санал авахаас өмнө хүчин төгөлдөр саналын хуудас санал авах байрны хаа нэгтгээ хэдэн зуу, мянгаараа байхыг зохисгүй гэж үзнэ.

### **Зөвлөмж #6**

Хэсгийн хороод сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэсэн сонгогчдын тооноос 10% илүү саналын хуудас захиалж авах тухай заалтыг хянаж үзэх хэрэгтэй. Улаанбаатар хотод хэсгийн хороодын нэрсийн жагсаалтад дунджаар 3,650 сонгогч бүртгэгдсэнийг авч үзвэл, хэт олон нөөц саналын хуудсыг зохисгүй, ноцтой байдлаар хэрэглээнд оруулж болзошгүй нөхцөл бүрдэхээр байна. Тэрчлэн бараг бүх нөөц саналын хуудсыг гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болгосон байна. Сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэсэн мянган сонгогч тутамд 30-аас ихгүй нөөц саналын хуудас нөөцлөх хэрэгтэй. Одоогийн зохицуулалтаар хэт олон ашиглаагүй саналын хуудас СЕХ-нд хадгалагдаж байна.

### **Зөвлөмж #7**

Сонгуулийн өдрөөс өмнө урьдчилан санал өгөх сонгогчдод зориулж маш цөөн тооны саналын хуудас хэсгийн хороодод хүргүүлэх хэрэгтэй. Найдвартай хадгалалт, үйл ажиллагааны зохистой талаас авч үзвэл, гарын үсэг зурж тамгалсан мянга мянган саналын хуудсыг сонгуулийн өдрийн өмнөх таван өдрийн турш 1700 гаруй “найдвартай бус” газар хадгалах нь зохистой бус явдал юм. Сонгууль эхлэхээс өмнө саналын хуудас их хэмжээгээр хэсгийн хороодод хүргүүлэхгүй байснаар сонгуулийн өдөр санал авах явцад гарын үсэг зурж, тамгалах журам бүрдүүлэх боломжтой.

### **Зөвлөмж #8**

Бэх түрхэх практикийг өөрчилж өөр арга нэвтрүүлэх асуудлыг авч үзэх эсвэл одоогийн хэрэглэж буй бэхний

төрлийг солих хэрэгтэй. Сонгогчийн зураг наасан сонгогчийн байнгын үнэмлэх нэвтрүүлэх саналыг авч үзэх нөхцөлд сонгуульд санал өгсний дараа үнэмлэхийг нүхэлж тамгалахаар загварчилбал дахин санал өгөхөөс сэргийлэх боломж бүрдэнэ.

### **Зөвлөмж #9**

Нам бус сонгуулийн мониторингийн байгууллага байгуулж иргэний нийгмийн оролцоог дэмжих, оролцох бололцоо нөхцөлөөр хангах талаар бодитой хүчин чармайлт гаргах хэрэгтэй төдийгүй цааш цаашдын сонгуульд дотоодын нам бус ажиглагчдыг сонгуульд оролцуулах талаар УИХ-ын Сонгуулийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулбал зохино.

### **Зөвлөмж #10**

Улс төрийн нам, эвслийн жагсаалтад эмэгтэй нэр дэвшигчдийн эзлэх хувь хэмжээнд босго тогтоох асуудлыг шинээр бүрэлдэх УИХ дахин авч үзэх нь зүйтэй. Эмэгтэй нэр дэвшигч болон УИХ-д сонгогдсон эмэгтэй гишүүдийн тоо харьцангуй цөөн байгаа нь ардчилал шинээр тогтож буй улс орнуудын чиг хандлага, сонгуулийг зохион байгуулахад монголын эмэгтэйчүүдийн гүйцэтгэсэн үүрэгтэй харьцуулбал ихээхэн хангалтгүй байна.



**V. Хавсралтууд****A. Төлөөлөгчдийн нэрс****Төлөөлөгчид:**

1. **Ноён Майкл Жонсон, Австрали**  
Парламентийн гишүүн
2. **Ноён Кристофер Грийн, Австрали**  
Гадаад явдал, худалдааны яам  
Гүйцэтгэх ажилтан, Хойд Ази
3. **Ноён Алан Хамсон, Канад Улс**  
Бээжин дэх Канадын элчин сайдын яам  
(Улс төр хариуцсан) Хоёрдугаар нарийн бичгийн  
дарга, дэд консул
4. **Ноён Лукмансжах Чалил, Индонези Улс**  
Индонезийн Сонгуулийн хороо (KPU)  
Олон нийтийн харилцаа, оролцооны товчооны  
дарга
5. **Ноён Самино Портоно, Индонези Улс**  
Сонгуулийн шинэчлэлийн төв  
Судалгааны ахлах ажилтан
6. **Ноён Такахиро Ишизаки, Япон Улс**  
Монгол Улс дахь Япон Улсын элчин сайдын яам
7. **Хатагтай Саюури Мураки, Япон Улс**  
Монгол Улс дахь Япон Улсын элчин сайдын яам
8. **Ноён Фердинанд Т. Рафанан, Филиппин Улс**  
Сонгуулийн хороо (COMELEC)  
Хуулийн хэлтсийн дарга
9. **Ноён Еүн-Кэүн Лий, БНСУ**  
Бусаны Сонгуулийн хороо  
Менежментийн хэлтсийн дарга
10. **Ноён Жүү-сунг Жо, БНСУ**  
Гадаад явдал, худалдааны яам  
Хүний эрх, нийгмийн явдлын хэлтэс  
Хоёрдугаар нарийн бичгийн дарга

11. **Хатагтай Бускорн Пругсапонгсе, Тайланд**  
Бээжин дэх Тайландын элчин сайдын яам
12. **Ноён Чанатип Бунйакет, Тайланд**  
Сонгуулийн хороо  
Сонгуулийн судалгаа, үнэлгээний хэлтсийн дарга
13. **Ноён Агостиньо Симао Баррето, Зүүн Тимор**  
Гадаад явдлын яам  
Сайдын Гадаад хэргийн алба  
Ахлах зөвлөх
14. **Ноён Фаустино Кардосо Гомес, Зүүн Тимор**  
Сонгуулийн үндэсний хорооны ерөнхийлөгч
15. **Ноён Крис Кампонова, АНУ**  
АНУ-ын Төрийн департамент  
Ардчилал, хүний эрх, хөдөлмөрийн товчооны  
зөвлөх
16. **Ноён Роберт Бенжамин, АНУ**  
Үндэсний ардчиллын хүрээлэн  
Төв ба Зүүн Европын хэлтсийн дарга

### **БНОУХ-ийн ажилтнууд:**

1. **Хатагтай Кимбер Шиэрэр**  
БНОУХ-ийн Азийн хэлтсийн орлогч захирал
2. **Ноён Крис Вайрод**  
БНОУХ-ийн Зүүн Тимор Улс дахь төлөөлөгчийн  
газрын захирал
3. **Ноён Брайн Мэффорд**  
БНОУХ-ийн Украин Улс дахь төлөөлөгчийн газрын  
ажилтан
4. **Хатагтай Сара Тэйлор**  
БНОУХ-ийн Бангладеш Улс, Малайзи Улсыг  
хариуцсан ажилтан
5. **Ноён Жон Миллэр**  
БНОУХ-ийн Монгол Улс, Камбожи Улсыг хариуцсан  
ажилтан

6. **Ноён Адам Кинг**  
БНОУХ-ийн БНХАУ-ыг хариуцсан туслах ажилтан
7. **Ноён Хүүжий Өрнөх**  
БНОУХ-ийн Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын  
ахлах ажилтан
8. **Хатагтай Итрат Амин**  
БНОУХ-ийн Бангладеш Улс дахь төлөөлөгчийн  
газрын ахлах ажилтан
9. **Ноён Райн Жэнсен**  
БНОУХ-ийн Монгол Улс, БНАСАУ-ыг хариуцсан  
ажилтан асан



## **Б. АНДАТТ-ийн төлөөлөгчдийн 2008 оны 6 дугаар сарын 30- ний өдөр гаргасан урьдчилсан мэдэгдэл**

### **Оршил**

Монгол Улсын Засгийн Газар болон Сонгуулийн Ерөнхий Хорооны урилгаар Ази Номхон Далайн Ардчиллын Төлөө Түншлэл (АНДАТТ) байгууллагын хүрээнд Австрали, Канад, Зүүн Тимор, Индонези, Япон, Филиппин, БНСУ, Тайланд, АНУ зэрэг орны сонгуулийн байгууллага ба Засгийн газрын ажилтнууд, иргэний нийгмийн төлөөлөгчид, парламентийн гишүүд зэрэг нийт 16 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиглагчдын баг 2008 оны 6 сарын 29-нд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үйл ажиллагааг ажиглав.

Ажиглалт хийх бэлтгэл ажлын хүрээнд АНДАТТ-ийн ажиглагчдын баг сонгуулийн өмнөх өдрүүдэд Монголын улс төрийн намуудын төлөөлөгчид, сонгуулийн хорооны ажилтнууд, иргэний нийгмийн төлөөлөгчидтэй нэлээд олон удаа уулзалт, ярилцлага хийсэн. Сонгуулийн өдөр (2008 оны 6 сарын 29) ажиглагчдын есөн баг 110 гаруй сонгуулийн хэсгийн хороонд очиж санал өгөх явцыг ажиглав. Ажиглагчид нийтдээ 1500 гаруй сонгогч иргэд, хэсгийн хорооны ажилтнуудтай уулзаж ярилцсан болно.

### **Ажиглалтын урьдчилсан санал, дүгнэлт**

Энэхүү мэдэгдлийг гаргах цаг мөчид саналын хуудсыг тоолж дуусаагүй, сонгуулийн дүнг албан ёсоор зарлаагүй байсан тул дор дурдагдах *ажиглалтын үр дүн урьдчилсан бөгөөд бүрэн бус* болно.

Ажиглагчид урьдчилсан байдлаар ажигласан зүйлсэд үндэслэн Монголын нийт ард түмэн болон Монгол Улсын Засгийн газар, Сонгуулийн Ерөнхий Хороонд УИХ-ын тус ээлжит сонгуулийг амжилттай зохион байгуулж, сонгуульд идэвхтэй оролцсонд талархал дэвшүүлж байна. Сонгуулиар

Монгол Улсын сонгогч иргэдийн хүсэл зоригийг бодитой илтгэсэн үр дүн гарна гэдэгт төлөөлөгчид бүрэн итгэж байна. Саналын хуудас тоолох, сонгуулийн дүнг зарлах үйл явц улсын хэмжээнд төдийгүй сонгуулийн өдөр АНДАТТ-ийн ажиглагчдын очиж ажигласан сонгуулийн тойрог, хэсгийн хороодод бүрэн эцэслэж дуусаагүй байгааг ажиглагчид тэмдэглэсэн. Сонгуулийн үйл явц Монгол Улсын иргэдийн хүсэл сонирхлыг бодитой илэрхийлсэн хэмээн дүгнэхээс өмнө чухал шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Улаанбаатар хотын төв хэсэгт 7 дугаар сарын 1-нд хүч хэрэглэсэн ноцтой үйл явдал гарсанд төлөөлөгчид харамсаж байгаагаа илэрхийлэхийн сацуу улс төрийн нам, эвслийн удирдагчид энэхүү хүчирхийллийн ажиллагааг буруушааж байгаагаа олон нийтэд мэдэгдэж, гишүүд дэмжигчиддээ амгалан тайван байдлыг дахин сэргээхийг уриалахыг хүсч байна.

#### Урьдчилсан ажиглалтын дүн

АНДАТТ-ийн ажиглагчдын ажилласан газар бүрт улс төрийн сурталчилгааны үйл ажиллагаа идэвхтэй тайван явагдаж байлаа. Хэвлэмэл ба цахим мэдээллийн хэрэгслүүд харьцангуй тэнцвэрт түвшинд ажиллах нөхцлөөр хангагдсан тухай мэдээлсэн. Монгол Улсын иргэд ойлгомжтой, олон ургальч сонголт хийх боломжоор хангагдаж байсан.

Сонгуулийн тойрог, хэсгийн бүх түвшинд ажилтнуудын идэвх зүтгэл, бэлтгэл ажил өндөр түвшинд байсныг АНДАТТ-ийн ажиглагчид сайшаан тэмдэглэж байна. Сонгуульд эмэгтэйчүүдийн оролцоо харьцангуй өндөр байгааг нэлээд хэдэн ажиглагчид талархан дурдсан. Ажиглагчид томилогдсон тойргийн нутаг дэвсгэрт ажиллах явцад Сонгуулийн Ерөнхий Хороо болон тойргийн хороод, хэсгийн хороодын үйл ажиллагаа, тухайлбал сонгогчдын нэрсийн

жагсаалт, санал авах хуудас болон шаардлагатай бусад материалыг санал авах байруудад цаг тухайд нь хүргүүлэх бэлтгэл ажлыг сонгуулийн хууль тогтоомжийн дагуу явуулсныг ажигласан. АНДАТГ-ийн ажиглагчдын очиж ажигласан Улаанбаатар хотын бүх дүүрэг, орон нутгийн дөрвөн аймагт сонгуулийн хэсгийн хороод тогтоосон цагт нээж, хаасан. Сонгуулийн өдрийн турш сонгогчдын ирц өндөр байсан ч сонгуулийн хэсгийн хороод зохион байгуулалт сайтай, эмх цэгцтэй, үр дүнтэй ажиллагааг хангаж байв.

Сонгуулийн өдөр сонгогчид өөртэй итгэлтэй, дэг журамтай сонгуульд оролцож байсан боловч олон мандаттай томсгосон тойргууд бүхий сонгуулийн шинэ тогтолцооны санал өгөх журам ба шаардлагыг ойлгох талаар бага зэрэг бэрхшээл тулгарч байгаа нь ажиглагдсан.

Сонгогчдын нэрсийн жагсаалтын үнэн бодит байдлыг ажиглагчид анхааралтай авч үзсэн бөгөөд дараагийн сонгуулиар сонгогчдын нэрсийн жагсаалт, иргэний бүртгэл мэдээллийн журмыг анхаарч, сайжруулах шаардлагатай гэж үзэв. Гэвч дээрх бүртгэл, жагсаалтаас үүдсэн бэрхшээл нь сонгуулийн үр дүнд нөлөөлөх хэмжээгээр системтэйгээр ашигласан буюу маш олон тооны сонгогчдын сонгох эрхэд халдсан гэх нотолгоо ажиглагдаагүй.

Сонгогчдын ирц өндөр, нэг санал авах байрт ногдох сонгогчдын тоо олон, нэг санал авах хуудсанд олон нэр дэвшигчид тэмдэглэгдсэн зэрэг шалтгаанаас үүдэн санал тоолох, сонгуулийн дүнг мэдээлэх үйл явц маш их удааширч сунжирсан. Зарим ажиглагчдын зүгээс нэг санал авах байрт ногдох сонгогчдын тоог багасгах нь сонгуулийн үйл явцад эерэгээр нөлөөлнө гэж үзсэн ч сонгуулийн ерөнхий үйл явц зохион байгуулалт сайтай байсан талаар ажиглагчид эерэг сэтгэгдэлтэй байв. Сонгуулийн хэсгийн хороодын ажилтнууд зөрчилдсөн, улс төрийн нам, эвслийн ажиглагчид эсэргүүцсэн зэрэг шалтгаанаас тооллогын үйл явц саатаж доголдсон талаар ажиглагчид мэдээлээгүй. Гэвч саналын

хуудсыг бүрэн тоолж, тухайн хэсгийн хорооны дүн гарах хүртэл маш цөөн тооны ажиглагчид хэсгийн хороодод ажиглалт хийснийг тэмдэглэх нь зүйтэй.

Сонгуулийн өдөр сонгуулийн хэсгийн хороодод ажиллаж байсан 1000 гаруй ажиглагчдын ажилд АНДАТТ-ийн ажиглагчид сэтгэл дүүрэн байгааг илэрхийлж байв. Сонгуулийн ажиглагчид бүх санал авах байрт ажиллаж, улмаар зохих түвшинд бэлтгэгдэн, мэргэжлийн түвшинд ажиллаж байсан нь ажиглагдсан. Сонгуулийн үйл явцын шударга байдлыг хангахад дотоодын ажиглагчид чухал үүрэгтэй гэж үзэж байгаа ч сонгуулийн хэсгийн хороодод ажиллах ажиглагчдын багт нам бус, иргэний байгууллагуудын төлөөллийг оруулбал сонгуулийн үйл явцад олон нийтийн итгэх итгэлийг дээшлүүлэхэд эерэгээр нөлөөлөхийг санал болгож байна.

Эцэст нь АНДАТТ-ийн төлөөлөгчдийг халуун дотно хүлээж авсан явдалд Монгол Улсын холбогдох байгууллагуудад талархал илэрхийлэхийн сацуу ардчилсан төрөө тохинуулах үйлсэд гаргаж буй Монголын нийт ард түмний идэвх чармайлтад АНДАТТ-ийн 16 гишүүн бүхий ажиглагчдын баг баяр хүргэж байна. Сонгуулиар Монгол Улсын иргэдийн хүсэл сонирхлыг бодитой илтгэсэн үр дүн гарна гэдэгт төлөөлөгчид бүрэн итгэж байна.

## **В. Товч танилцуулга: Ази Номхон Далайн Ардчиллын Төлөө Түншлэл**

2007 оны 9 дүгээр сард Австрали Улсын Сидней хотноо болсон Ази Номхон Далайн Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны байгууллагын (АРЕС) гишүүн улс орны Дээд хэмжээний 15 дугаар уулзалтын үеэр Ерөхийлөгч Буш шинээр “Ази Номхон Далайн Ардчиллын Төлөө Түншлэл” байгууллагыг байгуулах санал дэвшүүлсэн. Энэхүү түншлэлийн хүрээнд эрх чөлөөт улс орнууд ардчиллын үнэт зүйлсийг дэмжих, ардчиллын институцийг бэхжүүлэх, Ази Номхон далайн бүс нутгийн хэмжээнд эрх чөлөөт нийгэм байгуулж, хөгжүүлэхийн төлөө ажиллаж буй холбогдох талуудад шаардлагатай тусламж дэмжлэг үзүүлэх зорилготой.

- Бусад бүс нутгаас ялгаатай нь Ази Номхон далайн бүсийн хэмжээнд хариуцлагатай, иргэний төлөөлөлт засгийн газар, хүний эрхийг хөгжүүлэхэд чиглэсэн улс орнуудын хүчин чармайлтыг дэмжих бүс нутгийн хэмжээний, олон талын хамтын ажиллагаат механизм байхгүй. Ардчиллыг хөгжүүлэх үйлсэд Ази–Номхон далайн ардчилал өндөр хөгжсөн улс орнууд нөөц боломж болон мэдлэг туршлагын дэмжлэг үзүүлэх түншлэлд нэгдсэнээр АНДАТТ дээрх хэрэгцээ шаардлагыг хангах боломжийг бүрдүүлж байна.
- АНДАТТ нь тус бүс нутаг дахь одоогийн болон шинээр гарч ирж буй олон улсын байгууллагууд, тэдний үйл хэрэгт өөрийн бодит хувь нэмрийг оруулна. Энэхүү түншлэл нь албан бус, практикт суурилсан, уян хатан, үр өгөөжтэй үйл ажиллагаа явуулна. Үүнд бодит хэрэгжилтэд чиглэсэн, сайн дурын арга хэмжээ, тусламж дэмжлэгийг анхаарч үзэхийн зэрэгцээ,

ардчиллыг хөгжүүлэх үйлсэд тодорхой улс орнуудыг харилцан дэмжихэд чиглэж ажиллана.

- Зарим олон усын байгууллагын гишүүнчлэл дэлхийн дахиныг хамарсан, үүнээс үүдэн гишүүнчлэлийн харилцан адилгүй байдал нь тухайн байгууллагын хүрээнд тусгайлан мэргэших, хамтран ажиллахад түвэг учруулах хандлагатай тул энэ тал дээр АНДАТТ хамтран ажиллахын зэрэгцээ ардчиллыг хөгжүүлэхэд чиглэсэн олон улсын байгууллагуудад дэмжлэг үзүүлнэ.
- Ази–Номхон далайн бүс нутгийн хэмжээнд ардчилал хөгжүүлэх талаар харилцан адилгүй түвшинд яваа улс орнуудын хэрэгцээ шаардлагад тулгуурлан зохих дэмжлэг үзүүлнэ. АНДАТТ-ийн сүлжээ нь түүнд хандсан гишүүн болон гишүүн-бус аливаа улс оронтой хамтарч ажиллахад бэлэн байдаг.
- АНДАТТ-ийн санаачилгаас дурдвал: сонгууль ажиглах ба дэмжлэг үзүүлэх сүлжээ; хуулийг сахин дээдлэхийг дэмжих хүчин чармайлтын талаарх шилдэг жишиг ба туршлага; хариуцлагын тогтолцоо, ил тод байдлыг дээшлүүлэх, сайн засаглалын хүчин чадавхийг сайжруулах; ардчилсан зарчим болон улс төрийн нам, төр засгийн байгууллагуудыг бэхжүүлэх; хүний эрх, бие даасан чөлөөт хэвлэл мэдээлэл, зөвшилцөх ба үл ялгаварлах зарчим, иргэний нийгмийг хөгжүүлэх зэрэг болно.

АНДАТТ-ийн анхны санал санаачлагын нэг хэсэг нь 2008 оны 6 дугаар сарын 29-ний өдөр болсон Монгол Улсын Их Хурлын сонгуулийг ажиглах олон улсын сонгуулийн ажиглагчдын үйл ажиллагаанд оролцох явдал байв. Монгол Улсын Засгийн Газар энэхүү санаачлагыг зөвшөөрч, АНДАТТ-ийн төлөөлөгчдийг найрсгаар хүлээн авсан билээ.

**Г. Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хорооноос гаргасан УИХ-ын 2008 оны сонгуулийн нэгдсэн дүн: 2008 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар**

Аймаг, хотын нэр	Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчийн тоо	Савал өгсөн сонгогчийн тоо	Хувь	Нэр дэвшигчийн овог, нэр	Нэр дэвшүүлсэн субъект	Нэр дэвшигчийн тоо	Хувь
Архангай аймаг	54,140	43,271	79.92	Н.Багбаяр	АН	23622	55.47
				Р.Гончигдорж	АН	21020	49.36
				С.Ламбаа	АН	20526	48.20
Баян-Өлгий аймаг	52,543	42,417	80.73	Х.Жекей	МАХН	23257	56.47
				А.Тлейхан	МАХН	22967	55.76
				Х.Баделхан	МАХН	20583	49.97
Баянхонгор аймаг	48,500	39,226	80.88	Г.Занданшатар	МАХН	19895	51.53
				Б.Багбаяр	АН	17717	45.89
				Х.Баттулга	АН	21122	54.71
Булган аймаг	34,223	27,666	80.84	Э.Мөнх-Очир	МАХН	17121	62.91
				Ц.Цэнгэл	МАХН	11514	42.31
Говь-Алтай аймаг	34,313	28,264	82.37	Ц.Дашдорж	МАХН	17699	63.35
				Ж.Энхбаяр	МАХН	19015	68.06
Говьсүмбэр, Дорноговь аймаг	43,152	32,609	75.57	Ж.Батсуурь	МАХН	15013	46.60
				Я.Батсуурь	АН	17768	55.16
Дорнод аймаг	45,653	34,493	75.55	Д.Одбаяр	МАХН	13039	38.54
				Ц.Шинэбаяр	МАХН	13782	40.74
				П.Алтангэрэл	АН	13356	39.48
Дундговь аймаг	27,506	22,391	81.40	Х.Наранхүү	МАХН	11971	54.23
				Р.Раш	МАХН	10558	47.83
Завхан аймаг	46,623	37,326	80.06	Д.Балдан-Очир	МАХН	21309	57.71
				Д.Оюунхорол	МАХН	17589	47.64
				Ш.Сайхансамбуу	МАХН	17989	48.72
Өвөрхангай аймаг	70,204	54,007	76.93	Д.Лүндэжанцан	МАХН	25685	48.59
				Г.Батхүү	АН	29309	55.44
				Д.Зоригт	АН	27776	52.54
Энхболд				Э.Энхболд	АН	26003	49.19
Өмнөговь аймаг	31,036	25,142	81.01	Х.Бадамсүрэн	МАХН	13617	54.71
				Ц.Баярсайхан	АН	10103	40.59
Сүхбаатар аймаг	34,042	28,496	83.71	Ч.Улаан	МАХН	18246	65.15
				Р.Буд	МАХН	14117	50.40
Сэлэнгэ аймаг	60,945	45,192	74.15	О.Чулуунбат	МАХН	23944	53.81
				Э.Баг-Үүл	АН	22016	49.48
				С.Баярцогт	АН	25941	58.30
Төв аймаг	53,593	39,892	74.44	С.Батболд	МАХН	22599	57.58
				Д.Лондог	МАХН	17693	45.08
				М.Энхболд	МАХН	23051	58.73
				Н.Энхболд	МАХН	22857	58.24
Увс аймаг	46,974	39,255	83.57	Б.Чойжилсүрэн	МАХН	22044	57.34
				Ц.Нямдорж	МАХН	21198	55.14
				Ч.Хүрэлбаатар	МАХН	23985	62.39

Ховд аймаг	47,700	37,917	79.49	С.Бямбацогт Д.Дэмбэрэл Р.Амаржаргал	МАХН МАХН АН	19344 15708 14998	52.08 42.29 40.38
Хөвсгөл аймаг	74,668	58,253	78.02	Ц.Даваасүрэн Ө.Энхтүвшин Л.Гундалай Ц.Сэвдэнчиг	МАХН МАХН АН АН	26177 26232 30224 29756	45.97 45.77 52.73 51.92
Хэнтий аймаг	42,150	32,544	77.21	Д.Арвин Б.Баг-Эрдэнэ Н.Ганбямба	МАХН МАХН МАХН	14161 15710 16153	44.29 49.14 50.52
Дархан-Уул аймаг	49,361	39,759	80.55	Ж.Сүхбаатар Д.Хайнхярваа Л.Гансүх	МАХН МАХН АН	14823 17259 19679	37.80 44.01 50.18
Орхон аймаг	54,987	40,366	73.41	Д.Дамба-Очир Д.Одхүү	МАХН АН	19511 19195	48.78 47.99
Хан-Уул, Багахангай, Багануур дүүрэг	72,781	54,716	75.18	Д.Загджав Л.Болд	МАХН АН	18132 20135	33.71 37.43
Баянзүрх, Налайх дүүрэг	158,467	107,621	67.91	Ц.Батбаяр Д.Ганхуяг Ч.Сайханбилэг З.Алтай	МАХН АН АН Бие даан нэр дэвшигч	41542 37321 55790 60320	39.21 35.23 52.66 56.94
Сүхбаатар дүүрэг	67,999	49,188	72.34	С.Баяр С.Батболд Л.Гангөмөр	МАХН МАХН АН	29941 23091 22058	61.94 47.77 45.64
Чингэлтэй дүүрэг	74,583	57,702	77.37	Д.Очирбат Г.Баярсайхан Ц.Элбэгдорж	МАХН АН АН	20296 20031 30893	36.01 35.54 54.82
Баянгол дүүрэг*	87,390	67,227	76.90	Ц.Мөнх-Оргил Х.Тэмүүжин С.Эрдэнэ Д.Энхбат	МАХН АН АН Иргэний эвсэл		
Сонгино-хайрхан дүүрэг	129,084	94,508	73.21	Д.Тэрбишдагва Н.Алтанхуяг Д.Кёкүшозан Батбаяр С.Оюун	МАХН АН АН АН ИЗН	38525 36664 54926 34319	41.34 39.34 58.94 36.83
Нийслэлийн дүн	560,304	430,962	73.01				
<b>Улсын дүн</b>	<b>1,542,617</b>	<b>1,179,448</b>	<b>76.46%</b>				

\* Энэхүү тайланг хэвлэж гаргах үед Сонгуулийн Ерөнхий хорооноос Баянгол дүүргийн тойргийн сонгуулийн дүнг эцэслэн баталгаажуулаагүй байсан бөгөөд тус тойргоос урьдчилан сонгогдсон дөрвөн нэр дэвшигчийн хэн нь ч УИХ-ын гишүүний тангарагаа өргөөгүй байсан.

**Д. Гадаадын ажиглагч Монгол Улсын Их хурлын сонгуулийг ажиглах тухай журам**

*Сонгуулийн ерөнхий хорооны  
2008 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн  
07 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт*

*Нэг. Нийтлэг зүйл*

1.1. Улсын Их Хурлын сонгуулийг ажиглах гадаадын ажиглагчийн үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Улсын Их Хурлын сонгуулийг ажиглах хүсэлтээ Сонгуулийн ерөнхий хороонд албан ёсоор гаргаж, бүртгүүлэн үнэмлэх авсан Олон улсын байгууллага, гадаад улсын Төрийн болон Төрийн бус байгууллагын томилсон этгээдийг “гадаадын ажиглагч” гэнэ.

1.3. Гадаадын ажиглагч нь УИХ-ын сонгуулийг ажиглах ажиллагаагаа Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд чөлөөтэй явуулна.

1.4. Гадаадын ажиглагчийн Монгол Улсад зорчих эрх болон зардлыг илгээсэн буюу ажиглагч хариуцна.

1.5. Гадаадын ажиглагч нь сонгуулийг ажиглах үедээ Сонгуулийн ерөнхий хорооноос олгосон гадаадын ажиглагчийн үнэмлэхээ энгэртээ зүүсэн байна.

1.6. Гадаадын ажиглагчийн бүрэн эрх нь Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлж үнэмлэх авснаар эхэлж, сонгуулийн албан ёсны дүн гарсан өдрөөр дуусгавар болно.

*Хоёр. Гадаадын ажиглагчийн бүрдүүлэх баримт бичиг*

- 2.1. Бүртгүүлэхэд дараах баримт бичиг бүрдүүлнэ:
  - 2.1.1. Энэхүү журмын хавсралтаар баталсан гадаадын ажиглагчийн товч анкет;
  - 2.1.2. Биеийн байцаалт /паспорт, үнэмлэх/;
  - 2.1.3. Цээж зураг /4x6/ 1 хувь;
  - 2.1.4. Санал авах өдрөөс өмнө сонгууль ажиглах тухай хүсэлтээ Сонгуулийн ерөнхий хороонд гаргасан байх.

*Гурав. Гадаадын ажиглагчийн эрх*

- 3.1. Гадаадын ажиглагч дараах эрх эдэлнэ:
  - 3.1.1. Сонгуулийн хороодын ажлын зохион байгуулалтын талаар мэдээлэл авах;
  - 3.1.2. Сонгуулийн тойрог, түүний салбар болон хэсгийн хорооны үйл ажиллагаа, санал авах байрны зохион байгуулалт, сонгогчдын нэрийн жагсаалттай танилцах;
  - 3.1.3. Санал авах өдөр санал авах байранд ажиглалт хийх;
  - 3.1.4. Саналын хайрцгийг шалган битүүмжлэх, санал авах, саналын хайрцгийг нээх, санал тоолох, сонгуулийн дүнг гаргах ажиллагааг хөндлөнгөөс ажиглах;
  - 3.1.5. Сонгогчийн урьдчилан санал өгөх ажиллагааг ажиглах;
  - 3.1.6. Санал авах ажиллагаа дууссаны дараа сонгуулийг ажигласан санал дүгнэлтээ Сонгуулийн ерөнхий хороонд гаргах; хэвлэл мэдээллийн хэрэгслээр илэрхийлэх;
  - 3.1.7. Сонгуулийг ажиглах үедээ гэрэл зураг авч, дүрс бичлэг хийх.

*Дөрөв. Гадаадын ажиглагч болон түүнийг урьсан  
байгууллагын үүрэг*

4.1. Гадаадын ажиглагч дараахь үүрэг хүлээнэ:

4.1.1. Монгол Улсын Үндсэн хууль болон сонгуулийн тухай хууль тогтоомжийг хүндэтгэн сахих;

4.1.2. Сонгуулийг ажиглахдаа сонгуулийн хороодын үйл ажиллагаанд болон саналаа нууцаар гаргаж буй сонгогчийн эрхэд саад учруулахгүй байх;

4.1.3. Нам, эвсэл, нэр дэвшигчийг дэмжсэн буюу эсэргүүцсэн сурталчилгааны зүйлс хэрэглэх, биедээ авч явахгүй байх;

4.2. Гадаадын ажиглагчийг урьсан байгууллага дор дурьдсан үүрэгтэй байна:

4.2.1. Гадаадын ажиглагчийг Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлэх;

4.2.2. Гадаадын ажиглагчийн үйлчилгээг бүрэн хариуцах;

4.2.3. Энэхүү журмын 3.1 дэх хэсэгт заасан эрхээ хэрэгжүүлэхэд нь тэдэнд туслалцаа үзүүлэх;

4.2.4. Гадаадын ажиглагчийн орчуулагч энэ журмын 4.1.-д заасан үүргийг хүлээнэ.

4.3. Гадаадын ажиглагч нь 3.1-д заасан эрхээ сонгуулийн үйл явцыг ажиглахаас өөрөөр нам, эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгаанд оролцох болон бусад үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно.

4.4. Гадаадын ажиглагч энэ журмын 4.1, 4.3-т заасныг зөрчсөн бол Сонгуулийн ерөнхий хороо сонгууль ажиглах эрхийг хүчингүй болгон, тэмдэглэл үйлдэж үнэмлэхийг хураан авна.



**Е. Санал тоолох, дүн гаргах ажлыг зохион байгуулах заавар**

*Сонгуулийн ерөнхий хорооны  
2008 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн  
21 дүгээр тогтоолын хавсралт*

*Нэг. Нийтлэг үндэслэл*

1.1. Сонгогчдын санал тоолох, сонгуулийн дүн гаргах, түүнийг мэдээлэх үйл ажиллагааг зохицуулахад энэхүү зааврын зорилго оршино.

1.2. Санал тоолох ажиллагаа 22 цагт эхэлж, тасралтгүй, ил тод, нээлттэй байх зарчмаар явагдах бөгөөд хэсгийн хэмжээнд санал хураалтын дүн гаргаж дуустал үргэлжилнэ.

1.3. Санал тоолох, дүн гаргах ажиллагаанд ажиглагчид, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчид байлцаж болно.

*Хоёр. Хэсгийн хорооны ажлын зохион байгуулалт*

2.1. Санал авах өдрийн өмнөх өдөр хэсгийн хорооны хуралдаанаар санал тоолох, дүн гаргах ажилд хэсгийн хорооны гишүүдийг хуваарилж, ажил үүргийн хуваарийг батална.

2.2. Санал тоолох, дүн гаргах ажиллагааг хэсгийн хорооны дарга удирдан явуулах бөгөөд бүхий л үйл явцыг санал тоолох байранд байгаа хүмүүст сонсогдохоор тайлбарлан, санал тоолох үйл явцын хэсгийн хорооны хуралдааны тэмдэглэл /цаашид “тэмдэглэл” гэх/, санал тооллогын болон санал хураалтын дүнгийн нэгтгэлд /цаашид “дүнгийн нэгтгэл” гэх/ тэмдэглэх бололцоо олгоно.

2.3. Хэсгийн хорооны нарийн бичгийн дарга санал тоолох, дүн гаргах үйл явцын талаар тэмдэглэл үйлдэнэ. Тэмдэглэлд санал тоолох, дүн гаргах ажилтай холбоотой бүхий л мэдээлэл, тоо баримтуудыг цаг хугацаатай нь тэмдэглэж хэсгийн хорооны гишүүд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.


2.4. Хэсгийн хорооноос баталсан гишүүдийн ажил үүргийн хуваарийн дагуу аль нэг гишүүн дүнгийн нэгтгэлд тоон мэдээллийг оруулахдаа цэвэр, тод, гаргацтай бичнэ.

2.5. Ажиглагч, хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтнуудад харагдахаар зай, байрлалд санал тоолох, дүн гаргах ажиллагааг явуулна.

*Гурав. Санал тоолох ажиллагаа*

3.1. Санал хураах ажиллагаа дууссаныг хэсгийн хорооны дарга зарлаж, санал тоолохын өмнөх бэлтгэл ажлыг эхэлнэ. Санал тоолох, дүн гаргах үеийн бүхий л үйл ажиллагааг хэсгийн хорооны дарга тухай бүрт нь зарлан, хөтөлж явуулна.

3.2. Санал тоолох ажиллагааг эхлэхийн өмнө санал авах байрыг доорх зурагт үзүүлснээр өөрчлөн засна.



Зураг 1

3.3. Санал тоолоход шаардлагатай баримт бичиг, бичиг хэргийн хэрэгслийг бэлтгэсэн байна. Үүнд:

3.3.1. санал тоолох маягт /1 дүгээр хавсралт/;

3.3.2. санал тоолсон дүнгийн товчоо /2 дугаар хавсралт/;

3.3.3. санал тооллогын болон санал хураалтын дүнгийн нэгтгэл /3 дугаар хавсралт/;

3.3.4. саналын хуудсыг ангилан хийх тусгай сав;

3.3.5. санал хураасан дүн тэмдэглэхэд шаардлагатай үзэг, эсгий бал, цавуу, хайч, скоч, зэрэг бичиг хэргийн зүйлс;

3.3.6. санал тоолох үйл явцын талаарх хэсгийн хорооны хуралдааны тэмдэглэлийн маягт;

3.3.7. санал тоолсон дүнгийн тухай сонгуулийн хэсгийн хорооны тогтоолын маягт.

3.4. Дүнгийн нэгтгэлийн маягтуудыг /3.3.2., 3.3.3./ хэсгийн хорооны гишүүд, ажиглагч, хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтнуудад харагдахаар газар хананд байрлуулна.

3.5. Сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчийн тоо, шилжин ирсэн, явсан, урьдчилан болон зөөврийн битүүмжилсэн хайрцгаар саналаа өгсөн сонгогчдын тоог сонгогчдын нэрийн жагсаалтыг үндэслэн тус бүрд нь гарган зарлаж, тэмдэглэл, дүнгийн нэгтгэлд тэмдэглэнэ.

3.6. Сонгогчдын нэрийн жагсаалтын хуудас бүрийн доод талд тухайн хуудсанд бичигдсэн сонгогчдын тоо, санал өгсөн сонгогчдын тоог бичиж, хэсгийн хорооны тэмдэг дарна.

3.7. Хэсгийн хороонд хүлээн авсан сонгогчийн үнэмлэхний тоо, үүнээс сонгогчдод олгосон, буруу бичсэнээс хүчингүй болгосон, алдаж үрэгдүүлсэн болон ашиглагдаагүй үлдсэн үнэмлэхний тоог гарган, тэмдэглэл, дүнгийн нэгтгэлд

тэмдэглэнэ. Ашиглагдаагүй үлдсэн болон хүчингүй болгосон сонгогчийн үнэмлэхийг боож битүүмжилнэ. Боодол дээр үнэмлэхний тоог бичнэ. Сонгогчийн үнэмлэхний зарцуулалтын тайланг батлагдсан маягтын дагуу гаргана.

3.8. Урьдчилан битүүмжилж болон зөөврийн хайрцгаар санал авахад, санал авах өдөр санал авах байранд зарцуулсан саналын хуудасны тоог тус бүрд нь гаргасны дараа нийт ашигласан саналын хуудасны тоог нэгтгэн, тэмдэглэл, дүнгийн нэгтгэлд тэмдэглэнэ.

3.9. Санал авахад зарцуулсан саналын хуудасны тоог саналын хайрцгаас гарсан болон буруу тэмдэглэл хийснээс хураагдсан саналын хуудасны нийлбэрээр тооцож гаргана.

3.10. Санал авах явцад буруу тэмдэглэл хийснээс хураагдсан болон зарцуулагдаагүй үлдсэн саналын хуудсыг тус тусд нь тоолж, саналын хуудасны баруун дээд өнцгийг хайчлан, тусгай саванд хийж битүүмжлэн, тэмдэглэл, дүнгийн нэгтгэлд тэмдэглэнэ. Тусгай саван дээр битүүмжилсэн баримтын нэр, тоо ширхэгийг бичнэ.



Зураг 2

3.11. Санал авахад зарцуулсан болон буруу тэмдэглэл хийснээс хураагдсан, зарцуулагдаагүй үлдсэн саналын хуудасны нийлбэр нь тухайн хэсгийн хороо анх хүлээн авсан нийт саналын хуудасны тоотой тэнцүү байна. Хэрэв зөрүү гарвал хэсгийн хороо шалтгааныг тогтоож, зайлшгүй шаардлага гарвал буруу тэмдэглэл хийснээс хураагдсан болон зарцуулагдаагүй үйлдсэн саналын хуудсыг дахин тоолж, энэ тухай тэмдэглэл үйлдэн, санал тоолох ажиллагаанд оролцогчдоор гарын үсэг зуруулна.

3.12. Дээрх тооцоог нэгтгэн нягталсны дараа саналын хайрцгуудаас гарах нийт саналын хуудсын тоог урьдчилан тогтоож, санал өгсөн сонгогчийн тоо нь санал авахад зарцуулсан саналын хуудасны тоотой тохирч буй эсэхийг нягталж, тэмдэглэлд тусгана.

3.13. Тооцооны ажлыг дуусгасны дараа саналын хайрцгуудыг дэс дараатайгаар нээж, хайрцаг тус бүрээр саналын хуудсыг тоолно. Ингэхдээ саналын хайрцгийн болон лацны дугаарыг тэмдэглэлд тусгана.

3.14. Урьдчилан битүүмжилж саналаа өгсөн сонгогчийн дугтуйтай саналын хуудсыг дугтуйнаас гарган, сонгогчийн саналын нууцлалыг алдагдуулахгүйгээр бусад саналын хуудастай холино.

3.15. Зөөврийн битүүмжилсэн хайрцаг, нэмэлт нэрийн жагсаалтаар сонгогчийн саналыг авсан хайрцаг дахь саналын хуудсыг тусд нь, суурин хайрцаг дахь саналын хуудсыг тоолсны дараа тоолно.

3.16. Саналын хайрцаг бүрээс гарсан саналын хуудсыг хүчинтэй болон хүчингүй саналын хуудсаар ангилан тоолж, тэмдэглэлд тусгана. Үүний дараа хүчингүй саналын хуудсыг тусгай саванд хийж битүүмжилнэ. Тусгай саван дээр битүүмжилсэн баримтын нэр, тоо ширхэгийг бичнэ.

3.17. Саналын хуудсанд огт тэмдэглэл хийгээгүй, эсвэл бүх нэр дэвшигчийн нэрийг дарсан саналын хуудсыг хүчинтэй саналын хуудагт тооцно. Эдгээр хуудсыг нэр дэвшигчдийн төлөө санал өгсөн хүчинтэй саналын хуудаснаас тусд нь багцлан тусгай саванд хийж битүүмжилнэ. Тусгай саван дээр битүүмжилсэн баримтын нэр, тоо ширхэгийг бичнэ. Саналын хуудсыг ангилах ажиллагаанд бүх гишүүд оролцоно.

3.18. Нэр дэвшигчдийн төлөө санал өгсөн хүчинтэй саналын хуудсыг 30, 30 ширхэгээр багцлана. Үүний дараа санал тоолох ажиллагаанд оролцож байгаа хэсгийн хорооны гишүүдийг хоёр хэсэг болгон ажиллуулна. Хэсгийн хорооны гишүүдийг ийнхүү хуваарилахдаа нам, эвслийн төлөөллийг тэгш байхаар зохион байгуулна.

3.19. Нэгдүгээр хэсэг нь 3-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба аль нэг гишүүн нь хүчинтэй саналын хуудас тус бүрээс санал авсан нэр дэвшигчдийн нэрийг бусад гишүүдэд сонсогдохоор зарлан тоолж, ширээний голд бусад бүх гишүүдэд харагдахаар байрлалд тавина. Энэ үед нэгдүгээр хэсгийн бусад гишүүд, ажиглагчид нэр дэвшигчдийн авсан саналыг зарлан тоолж буй гишүүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс хяналт тавина.

3.20. Тухайн тойрогт ногдох мандатын тооноос дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэгдсэн саналын хуудсыг хүчинтэйд тооцож, нэр дэвшигч бүрийн төлөө өгсөн саналыг тоолно.

3.21. Хоёрдугаар хэсгийн гишүүн бүр энэхүү журмын 1 дүгээр хавсралтад заасан санал тоолох маягтад нэр дэвшигч бүрийн авсан саналыг тэмдэглэнэ.

3.22. Багц тус бүрийн дүнг тухай бүрт нь 1 дүгээр хавсралтын дагуу гарган, дүнг тулгаж шалгана. Маягтын хөндлөн хэсгийн хамгийн хойд талын нүдэнд тухайн нэр дэвшигчийн авсан саналын дүнг, босоо хэсгийн хамгийн доод талын нүдэнд тухайн саналын хуудсанд хэдэн санал тэмдэглэгдсэнийг тус тус бичих ба босоогоор болон хөндлөнгөөр дүгнэсэн дүн хоорондоо тохирч байна. Багц тус бүрийн дүнг санал тоолсон товчооны томруулсан маягтад тэмдэглэнэ.

3.23. Багц тус бүрийн дүнг тухай бүрт нь нэгтгэн нягталсны дараа уг багцын саналын хуудсуудыг санал тоолох маягтын хамт боож тус тусд нь тавина.

3.24. Санал тоолсон товчооны дагуу нэр дэвшигч бүрийн авсан саналын дүнг нэгтгэн гаргах ба нэр дэвшигч бүрийн төлөө өгсөн саналын хувийг тухайн хэсгийн нийт хүчинтэй саналын хуудаст харьцуулан гаргаж зарлан, санал тоолох үйл явцын тэмдэглэл, дүнгийн нэгтгэлд тэмдэглэнэ.

3.25. Нэр дэвшигч бүрийн авсан саналыг тоолж, нэгтгэж дууссаны дараа хүчинтэй саналын хуудсыг багцлан боож, тусгай саванд хийж битүүмжилнэ. Тусгай саван дээр битүүмжилсэн баримтын нэр, тоо ширхэгийг бичнэ.

#### *Дөрөв. Санал хураалтын дүн гаргах*

4.1. Хэсгийн хороо санал тоолсон дүнг хуралдаанаараа хэлэлцэн шийдвэр гаргаж, уншиж сонгосны дараа хэсгийн санал хураалтын дүнг тойргийн хороонд мэдээлнэ. Саналын хайрцгаас гарсан саналын хуудас нь урьдчилж гаргасан саналын хуудасны тооцооноос зөрж, илүү гарсан бол, энэ нь тухайн хэсгийн санал хураалтын дүнд ноцтой нөлөөлөхөөр байвал нэн даруй тойргийн хороонд мэдэгдэнэ. Тойргийн хороо асуудлыг газар дээр нь очиж зохих шийдвэрийг гарган хэрэгжүүлнэ.

4.2. Хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга санал хураалтын хэсгийн дүнг гаргасан даруйд санал авсан дүнгийн тухай тогтоол, хуралдааны тэмдэглэл, санал тоолсон товчоо, дүнгийн нэгтгэл, ангилан тусгай саванд хийсэн бүх саналын хуудас зэрэг баримт бичгүүдийг салбар хороонд, салбар хороогүй бол тойргийн хороонд хүргэнэ.

4.3. Сонгуулийн баримт бичгийг дээд шатны хороодод хүргэх үед ажиглагчид өөрийн унаагаар дагалдан явж болно.

4.4. Тойргийн хороо салбар, хэсгийн хороодоос ирүүлсэн баримт бичгийг нэг бүрчлэн хүлээн авч, 3 хоногийн дотор санал хураалтын дүнг хуралдаанаараа хэлэлцэн шийдвэр гаргаж, Сонгуулийн ерөнхий хороонд утсаар мэдээлнэ.

4.5. Тойргийн хэмжээний сонгуулийн нэгдсэн дүнг батлагдсан маягтаар гарган, 2 хоногийн дотор тойргийн хорооны дарга, нарийн бичгийн дарга Сонгуулийн ерөнхий хороонд холбогдох бусад баримт бичгийн хамт хүлээлгэн өгнө.

4.6. Тойргийн хороо нь хэсгийн хороодоос тусгай саванд хийж битүүмжлэн ирүүлсэн саналын хуудасны боодлыг задлахыг хориглоно. Шаардлагатай тохиолдолд зохих байгууллагын шийдвэрээр битүүмжилсэн боодлыг задлан дахин тоолж болох бөгөөд энэ тухай тэмдэглэл үйлдэн, саналын хуудсыг дахин тоолох ажиллагаанд оролцсон бүх хүнээр гарын үсэг зуруулж, баталгаажуулна.

*Тав. Санал тоолох, дүн гаргах ажиллагааны үед  
хориглох зүйл*

5.1. Санал тоолох ажиллагааны үед дараахь зүйлийг хориглоно:

5.1.1. Санал авах байранд хэсгийн хорооны гишүүд, ажиглагчид, хэвлэл, мэдээллийн ажилтнууд, хамгаалалтын албаны ажилтнуудаас бусад этгээд байх;

5.1.2. Санал тоолох ажиллагааны үед санал тоолж буй байранд байгаа хүмүүс гар утас болон хөдөлгөөнт холбооны хэрэгсэл ашиглах;

5.1.3. Санал тоолох, дүн гаргах ажиллагаанд хэсгийн хорооны гишүүдээс бусад этгээдүүд хутгалдан оролцох, дарамт шахалт үзүүлэх;

5.1.4. Санал хураалтын дүн гаргаж, мэдээлэхээс өмнө санал авах байранд байгаа хүмүүс зөвшөөрөлгүйгээр гарах, санал авах байранд гаднаас хүн оруулах.

